



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 4/10

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийслэлийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын /НАГ-2022/16-11-ШТА-ГА/ тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумъяабазар), Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Д.Ганболд), Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга (Г.Баярсайхан), Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван), Нийслэлийн Эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж), “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат), Улаанбаатар зам засвар, арчлалтын газар (Б.Галхүү)-д тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Аудитын гуравдугаар хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газарт, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ



002010033

D:\Desktop\2022\Word\Тушаал\№13-2022.04.29. GA-batlagajuuлах тушаал.docx



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөх, ХАА зохион байгуулах, гүйцэтгүүлэх, шат шатны хяналтыг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг бүрэн мөрдөөгүйгээс зөрчлүүд дахин давтагдаж байна. Цаашид ажил хариуцсан байгууллага, албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.



АУДИТЫН СЭДЭВ: НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Улаанбаатар хот
2022 он

Товчилсон үг	3
Аудитын тайланг бэлтгэсэн:	Хүснэгтийн жагсаалт 4
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хавсралтын жагсаалт 4
Аудитын III хэлтэс	Дүрслэлийн жагсаалт 4
Хэлтсийн дарга, аудитын менежер:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл 5
Э.Мөнхмандах	Ерөнхий мэдээлэл 6
	А.Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх 7-9
	А.1 Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх, зохистой арга хэмжээг авч байна уу? 7-9
Аудитын менежер:	А.2. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлж хэрэгжилтийг хангуулсан уу? 9-12
Л.Саранбаатар	Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх. 13
Аудитор:	Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан уу? 13-19
М.Одгэрэл	Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү? 19-27
Э.Дөлгөөн	Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна уу? 27-33
Б.Золбаяр	Б.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг арилгуулсан уу? 31
Гэрээт ажилтан:	Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 11-327787
П.Энхбаяр	Тайланг НТАГ-ын http://www.audit.mn/ веб сайтаас үзнэ үү.
	Аудитын дүгнэлт 33
	Аудитын зөвлөмж 34
	Холбогдох байгууллагын санал 35
	Саналд өгсөн тайлбар 36
	Хавсралтууд 37-50

БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ЗД	Засаг дарга
ЗАА	Захирагчийн ажлын алба
МУ	Монгол Улс
НЗХГ	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
НБГ	Нийслэлийн Боловсролын газар
НД	Налайх дүүрэг
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
НӨАУГ	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТОӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зөвлөмж
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
УКА	Улсын комисс акт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	НИТХ-ын тогтоолоор баталсан 1 ТАХ-г НЗД-ын захирамжаар задалсан	10
Хүснэгт 2	Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ	11
Хүснэгт 3	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ	12
Хүснэгт 4	ТАХ-ний худалдан авалт	13
Хүснэгт 5	ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа	14
Хүснэгт 6	Хугацаа хоцорч эрх шилжүүлсэн ТАХ-ний төрөл	14
Хүснэгт 7	Үнэлгээний хороо байгуулсан хугацаа	15
Хүснэгт 8	Тендер зарласан ТАХ-ний тоо	15
Хүснэгт 9	Хойшлогдон зохион байгуулсан ТАХ-ний ХАА	16
Хүснэгт 10	ХАА-нд мөрдсөн журам /байгууллагаар/	16
Хүснэгт 11	Цахим системээр зарлаагүй ТАХ	17
Хүснэгт 12	ТАХ-ний гэрээний хэрэгжилт	19
Хүснэгт 13	Гүйцэтгэлийн шатанд баталгаажуулсан актууд	26
Хүснэгт 14	ТАХ-ний санхүүжилт	27
Хүснэгт 15	Бодит гүйцэтгэлд үндэслээгүй дутуу санхүүжилт олгосон ТАХ	28
Хавсралтын жагсаалт		
Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Нийслэлд 2021 онд хэрэгжих ТАХ-г салбараар эрэмбэлсэн байдал	34
Хавсралт 2	Нийслэлд 2021 онд шинээр хэрэгжүүлэх 39 багц ТАХ-г захирамжаар задалсан байдал /хураангуй/	34
Хавсралт 3	ТАХ-ний төрөл	35
Хавсралт 4	Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой зөрчлийн жагсаалт	36
Хавсралт 5	ТББ-т тусгасан зарим шаардлага хангаагүй гүйцэтгэгчдийн жагсаалт	36
Хавсралт 6	Дуусаагүй барилгын судалгаа	41
Хавсралт 7	Магадлалын дүгнэлтээр нэмэлт хөрөнгө шаардагдсан ТАХ	42
Хавсралт 8	Захиалагчаас шалтгаалж гэрээний хугацаанд дуусаагүй, эхлээгүй ТАХ	43
Хавсралт 9	Гүйцэтгэлийн шатанд баталгаажуулсан актууд	44
Хавсралт 10	Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтын Байгууллагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлт	46
Хавсралт 11	НӨАУГ бүртгэсэн хөрөнгө оруулалтын ажлын жагсаалт	48
Дүрслэлийн жагсаалт		
Дугаар	Гарчиг	Хуудас
Дүрслэл 1	Нийслэлд 2021 онд шинээр хэрэгжих ТАХ-ний төсөвт өртгийг салбараар ангилсан байдал	8

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамрах хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Нийслэлийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: ○ Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт үр дүнтэй эсэх; ○ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг НЗДТГ, УБ хотын ЗАА, НЗХГ, НБГ, НХААГ, НӨАУГ, “НХОГ” ОНӨААТҮГ болон холбогдох бусад газруудыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг Төрийн Аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим” MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020, “МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх, газар дээр нь тулган баталгаажуулах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг 3 дугаар хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, аудитор М.Одгэрэл, Э.Дөлгөөн, Б.Золбаяр, гэрээт ажилтан П.Энхбаяр нар гүйцэтгэв.
Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл	Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэв. Аудитад хамрагдагч, шалгагдагч байгууллага нь 2021 оны баримтыг архивын нэгж үүсгээгүй байсан нь талбарт ажиллах, баримт материал татах, тулган баталгаажуулахад хүндрэл бэрхшээлтэй байсан.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

НИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 02/11 дугаар тогтоолоор өмнөх онуудаас дамжин хэрэгжсэн болон шинээр хэрэгжих нийт 464,969.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 121 багц ТАХ-г баталсан.

НИТХ-ын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн III-03/28 дугаар тогтоолоор 28,307.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ-г нэмсэн, 17,117.7 сая төгрөгийг төсөвт өртөгтэй 2 ТАХ-г хасаж, 6 ТАХ-ний төсөвт өртөг, 2021 онд санхүүжих дүнг өөрчлөн тодотгож, нийт 460,533.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 130 багц ТАХ болгон баталсан.

Үүний 91 багц ТАХ нь шилжих, 39 багц ТАХ нь шинээр хэрэгжихээр байна.

Батлагдсан ТАХ-г эх үүсвэрээр нь ангилбал 353,431.6 сая төсөвт өртөгтэй 85 багц ТАХ нь нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар, 107,102.3 төгрөгийн төсөвт өртөгтэй 45 багц ТАХ нь нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжих байна.

НЗД-аас ТАХ-г худалдан авах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэхдээ нэршил, байршил, хүчин чадал зэргийг нарийвчлан ТАХ-ний төсөвт өртгийг задлах, хуваах байдлаар шилжүүлсэн нь НИТХ-ын тогтоолд батлагдсан 130 ТАХ-ний тоон дүнг нь өсгөж 1018 ТАХ болсон байна.

Нийт ТАХ-нээс 60,399.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 685 ТАХ нь 2021 онд шинээр хэрэгжих, 400,134.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 333 нь өмнөх онуудаас хэрэгжсэн ТАХ байна.

НЗД-аас харьяа 12 байгууллагад 32 удаагийн захирамжаар ТАХ-ний ХАА-г зохион байгуулах эрхийг шилжүүлсэн.

Харьяа байгууллагуудаас шинээр хэрэгжих 685 ТАХ-ний ХАА-г ТАХ-ний шинж чанараас хамааруулан багцлах, нэгтгэх байдлаар зохион байгуулжээ. 2021 онд 308 ТАХ-ний ХАА зохион байгуулсан. Үүнээс 39,273.3 төгрөгийн төсөвт өртөгтэй 261 ТАХ-ний гэрээ хийгдсэн, харин 22,639.0 төгрөгийн төсөвт өртөгтэй 47 ТАХ-ний үр дүн тухайн онд гараагүй байна. 2020 онд ХАА зохион байгуулж дуусаагүй байсан 48.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ХАА-ний үр дүн гарчээ.

Өмнөх онуудаас дамжин хийгдсэн болон 2021 онд шинээр эхэлсэн 394,871.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 992 ТАХ-нд нийт 18 газраас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

2021 оны ТАХ-нүүдээс 113,929.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 727 ТАХ буюу 73.2% нь хэрэгжиж дууссан, 207,655.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 193 ТАХ буюу 19.4% нь дуусаагүй он дамжин хэрэгжиж байна. Харин 38,217.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 73 ТАХ буюу 7.3% нь 2021 онд хэрэгжиж эхлээгүй байна.

Аудитын түүврийг хийхдээ МУ-ын Ерөнхий аудиторын 2018 оны А/351 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу эх олонлогийг бүхэлд нь хамруулах үүднээс 2021 онд хэрэгжсэн ТАХ-ний төсөвт өртөг болон төрөл тус бүрээс хамруулсан. Үүнд:

- Шинээр хэрэгжих 60,399.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 685 ТАХ-ээс 34,274.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 202 ТАХ буюу 29.4%-ийг төсөвлөлтийн түүвэрт;
- 2021 онд худалдан авалт зохион байгуулсан 39,273.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 261 ТАХ-ээс 28,837.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 178 ТАХ буюу 68.1%-ийг ХАА-ны түүвэрт;
- Хэрэгжиж дууссан 70,714.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 686 ТАХ-ээс 26,248.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 273 ТАХ буюу 40.0%-ийг гүйцэтгэлийн түүвэрт;
- 2021 онд 145,990.9 сая төгрөг санхүүжилт олгосон 171 багц ТАХ-ээс 45,449.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 240 ТАХ буюу 30%-ийг санхүүжилтийн түүвэрт тус тус хамруулсан.

БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ ЭСЭХ

А.1 Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх, зохистой арга хэмжээг авч байна уу ?

Төсвийн тухай хуулийн 12.1.4¹, 6.5², 67.3³ дахь заалтыг мөрдлөг болгож “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д үндэслэн Нийслэлийн 2021 оны төсвийг баталжээ.

2021 онд хэрэгжүүлэх ТАХ-г хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичигтэй уялдуулан, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, олон нийтийн саналд үндэслэсэн ТАХ-ний эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг баримтлан төлөвлөсөн байна.

А.1.1. Төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн үү ?

2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 39 багц ТАХ-г нийслэлийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” буюу дунд хугацааны баримт бичгүүдэд дээрх ТАХ нь туссан байна
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9⁴-д богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг буюу хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар тусгасан. Тус хуулийн хүрээнд НИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний 02/10 дугаар “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоолын 2.4⁵ дэх хэсэгт “Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г боловсруулж НИТХ-д хуралд өргөн мэдүүлэхийг НЗД-д даалгасан ч “МУ-ын 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө” батлагдаагүй шалтгаанаар “Нийслэлийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөө”-г батлуулаагүй учир дээрх ТАХ-нүүд нь богино хугацааны баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг тодруулах боломжгүй байна.

Дүгнэлт: 2021 онд хэрэгжихээр батлагдсан ТАХ-нүүдийг хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичигтэй уялдуулан төлөвлөжээ.

¹12.1.4.жилийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг төсвийн цаглаврыг баримтлан бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

² 6.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

³ 67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

⁴ 6.9 Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөв хамаарна;

⁵ “2.4 Монгол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө батлагдсаны дараа түүнд суурилсан Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлэх”

А.1.2 Жагсаалтад батлагдсан ТАХ-г хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн үү?

НЗД, ЗДТГ-ын холбогдох хэлтсүүдээс нийслэлийн 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд 2020.06.12-ны өдрийн 01/3105 дугаартай албан бичгээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авахад 50 байгууллагаас 2,337,172.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 802 санал ирүүлсэн байна.

Шинээр хэрэгжүүлэхээр баталсан 39 багц ТАХ-г арга хэмжээ тус бүрээр судалж үзэхэд ирүүлсэн саналуудад үндэслэгдсэн байна.

Дүгнэлт: 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-г хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байна.

А.1.3 ТАХ-ны ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн үү?

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1⁶, 6.5.2⁷, 6.5.5⁸, 67 дугаар зүйлийн 67.3⁹-д заасны дагуу ТАХ-г олон нийтээс санал бодолд тулгуурлан, ач холбогдолоор нь эрэмбэлэж хэрэгжүүлэх дарааллыг тогтоохоор заасан.


2021 онд хэрэгжүүлэх ТАХ-ний хувьд /Ковид-19 халдварт цар тахлаас шалтгаалж/ 2020 оны 11 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд ulaanbaatar.mn хуудсаар дамжуулан цахим байдлаар санал авахад хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, автозам барих, засварлах, нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, цахилгаан хангамжийг сайжруулах зэрэг 9 дүүргийн 157 иргэнээс 343 санал¹⁰ ирүүлжээ.

Иргэд олон нийтээс ирүүлсэн саналыг шинээр хэрэгжих 60,399.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 багц ТАХ-д дараах байдлаар 4 салбарт ангилан тусгасан байна.

Дүрслэл 1. Нийслэлд 2021 онд шинээр хэрэгжих ТАХ-ний төсөвт өртгийг салбараар ангилсан байдал

сая.төг

Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаал баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны



⁶ 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;

⁷ 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

⁸ 6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;

⁹ 67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

¹⁰ НЗДТГ-ын 2020.11.20-ны өдрийн “Нийслэлийн 2021 оны төсвийн төсөлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, төсвийн төсөлд тусгасан талаарх тайлан

журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4¹¹, 4.5¹², 5 дугаар зүйлийн 5.10¹³-д заасны дагуу ТАХ-г эрэмбэлэхдээ өмнөх оноос хэрэгжсэн ТАХ, их засвар, шинээр хэрэгжүүлэх ТАХ гэсэн дарааллаар, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлийн төслүүд байх гэсэн үзүүлэлтийг харгалздаг байна.

Нийслэлд хэрэгжих 460,533.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 130 багц ТАХ-г аудитаар эрэмбэлсэн эсэхийг тулгахад дараах байдалтай байна. Хавсралт 1

Эрэмбэлсэн байдлаас харахад өмнөх оноос хэрэгжүүлж буй ТАХ 91 буюу 87%, их засварт 46 ТАХ буюу 45.1%, шинээр хэрэгжүүлэх ТАХ 39 ТАХ буюу 13.0%-г тус тус эзэлж байна.

Иргэд, олон нийтийн ирүүлсэн саналыг үндэслэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой дараах ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- Хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийг сайжруулахад 55% буюу 253,206.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 ТАХ;
- Автозам барих, засварлах, нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх сайжруулахад 33% буюу 149,703.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 49 ТАХ;
- 57,623.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 ТАХ-г Төрийн үйлчилгээг сайжруулах болон нийгмийн салбарт тусгажээ.

Дүгнэлт: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-г төлөвлөхдөө олон нийтийн саналд үндэслэн ТАХ-ний эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг баримталсан байна.

А.2. ТАХ-г үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлж хэрэгжилтийг хангуулсан уу?

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангуулаагүй, хугацаандаа хэрэгжих боломжтой байдлыг тооцоогүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус зарим төсөл, арга хэмжээг төлөвлөсөн зэргээр төлөвлөлтийн хэрэгжилтийг дутуу хангасан байна.

А.2.1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангуулсан уу?

Төсвийн тухай хуульд шинээр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангасны дараа төсөвт тусган хэрэгжүүлэхээр заасан.

НИТХ-ын тогтоолд 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 60,399.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 багц ТАХ-нээс 17 нь төсөл нэг бүрээр туссан бол 46,800.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 багц ТАХ-г /668 болж задарсан/ Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4¹⁴, 29.4¹⁵ дэх заалтуудыг зөрчиж ерөнхий байдлаар тусгасан байна. Хавсралт 2.

Ерөнхий нэрээр баталснаас шалтгаалж хэрэгжилтийн үе шатанд нэршил, байршил, хүчин чадал, төсөвт өртөг нарийвчлан задрах, хуваагдах, зураг төсөв

¹¹ 4.4 Төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтлана. Үүнд:

¹² 4.5 Төсөл нь холбогдох Аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

¹³ 5.10. Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар нь төсөвт тусгах хөрөнгө оруулалтын төслийг тодорхойлж, шийдвэрлэхдээ энэхүү журмын 4.4-т заасан эрэмбийг баримтлах үүрэгтэй;

¹⁴ 29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

¹⁵ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

шаардагдах зэргээр ТАХ-ний хэрэгжих хугацаанд нөлөөлөх, хэрэгжихгүй болох зэрэг үр дагавар үүсгэж байна.

Харин ТАХ-г хэрэгжүүлэх шатанд тус ТАХ-нүүдийг НЗД-ын захирамжаар задалж, хэрэгжүүлэх байршил, нэр, ТАХ тус бүрийн өртөгийг тодорхой болгосон байна. Тухайлбал: “Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын засвар” ТАХ-г 5 ТАХ болгон задалж захирамжилсан.

Хүснэгт 1. НИТХ-ын тогтоолоор баталсан 1 ТАХ-г НЗД-ын захирамжаар задалсан

сая төг				
№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Батлагдсан төсөл, арга хэмжээний Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг
Ерөнхий нэрээр баталсан ТАХ				
1	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын засвар	2021	2021	300.0
НЗД-ын захирамжаар задарсан байдал				
1	Дүүргийн эрүүл мэндийн төвийн Нэгдсэн эмнэлгийн их засвар /ЧД, 4 дүгээр хороо/	2021	2021	70.0
2	Өргөө амаржих газрын барилгын их засвар /СБД, 1 дүгээр хороо/	2021	2021	70.0
3	Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн автобаазын их засвар /СБД, 6 дугаар хороо/	2021	2021	60.0
4	Амгалан амаржих газрын барилгын засвар /БЗД, 13 дугаар хороо/	2021	2021	70.0
5	Энэрэл эмнэлгийн барилгын их засвар /БЗД, 22 дугаар хороо/	2021	2021	30.0

Нийслэлд шинээр хэрэгжих 685 /захирамжаар задарсан тоо/ ТАХ-нээс зураг төсөв шаардлагатай 18,840.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 88 ТАХ-г түүвэрлэн төсөвлөлтийн шаардлага хангуулсан эсэхийг тулган баталгаажуулахад 843.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ-ний зураг төсвийг төсөв баталсаны дараа боловсруулжээ. Тухайлбал:

- Дээврийн их засвар, барилгын засвар, 136 дугаар цэцэрлэг /БЗД, 6 дугаар хороо/ ТАХ-ний зураг, төсвийг 2021.03.05-ны өдөр;
- Дээврийн их засвар, 122 дугаар цэцэрлэг /БЗД, 15 дугаар хороо/ ТАХ-ний зураг, төсвийг 2021.03.05-ны өдөр;
- Амгалан амаржих газрын барилгын засвар /БЗД, 13 дугаар хороо/ ТАХ-ний зураг, төсвийг 2021.03.05-ны өдөр;
- Гадна, дотор сантехникийн засвар, 107 дугаар цэцэрлэг /СХД, 14 дүгээр хороо/ ТАХ-ний зураг, төсвийг 2021.09.10-ны өдөр;
- 57 дугаар сургуулийн дотор сантехникийн засвар (ЧД, 11 дүгээр хороо) ТАХ-ний зураг, төсвийг 2021.11.23-ны өдөр;
- Хүрээ амаржих газрын цахилгаан, сантехникийн засвар (СБД, 5 дугаар хороо) ТАХ-ний зураг, төсвийг 2021.12.01-ний өдөр тус тус боловсруулж эхэлжээ.

НИТХ хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжүүлэх байршил, нэр, төсөвт өртөгийг тодорхойгүй, ерөнхий нэрээр, зураг төсөвгүй баталж Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4¹⁶, 29.4¹⁷-д заалтыг зөрчиж байгаа нь ТАХ-ний төлөвлөсөн хугацаа, төсөвт өртөг, гүйцэтгэл, санхүүжилт зэрэг хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр ашигт нөлөөлөх, ТАХ-ний төсөвт өртөгт өөрчлөлт орох нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал:

- НИТХ-ын 2020 оны 02/11 дүгээр тогтоолын 1-р хавсралтын Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтын А.21 дэх ТАХ буюу 17.000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Авто

¹⁶ 29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

¹⁷ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

замын нүхэн гарцын зураг төсөл, барилга угсралтын ажил” нэр байршил тодорхойгүй шалтгаанаар хасагдсан;

- Тогтоолын Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ тодотголоор ажлын тоо хэмжээ нэмэгдсэн шалтгаанаар 7,652.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй болж өөрчлөлт орсон.

НИТХ, НЗДТГ нь хуульд заасан шаардлагыг баримтлан хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, холбогдох зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг батлах шаардлагатай байна.

Иймд төсвийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмжийн биелэлтийг хангах талаар хариуцсан байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангуулаагүй байна.

А.2.2 ТАХ-г хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан уу?

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх 17,609.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 108 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг 0.4-195.4 сая төгрөгөөр дутуу, нийт 1,257.3 сая төгрөгөөр дутуу баталжээ.

Хүснэгт 2. Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ

Салбар	ТАХ-ний тоо	сая төг			
		Төсөвт өртөг	Батлагдсан Тухайн онд санхүүжих дүн	Санхүүжих дүнгийн зөрүү Тэнцүү хуваарилсан дүн	Зөрүү
Зураг төсөл	100	7,318.60	2,665.90	3,659.30	-993.4
Дэд бүтэц	8	4,575.10	2,023.70	2,287.60	-263.9
Нийт	108	11,893.70	4,689.60	5,946.90	-1,257.30

Дээрхи 108 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг 21%-иар дутуу баталсан нь Ковид-19 цар тахлын үед хувь хүний орлогын албан татварыг чөлөөлсөн, нийслэлийн төсвийн орлогыг бүрдүүлэхэд хүндрэл учирсантай холбоотой байна.

Энэ нь барилга байгууламж, зам тээвэр, дэд бүтцийн ажлууд төлөвлөсөн онд бүрэн хэрэгжиж дуусахгүй байх, он дамжин хэрэгжих, удаашрах, олон жилээр хэрэгжихгүй орхигдох зэргээр ажлын үр дүн бүтээмжид нөлөөлөх үр дагавартай байна.

Дүгнэлт: Санхүүжилтийг батлахдаа ТАХ-г хугацаандаа хэрэгжих боломжтой байдлыг тооцоогүй байна.

А.2.3 Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан уу?

Төсвийн тухай хуулийн 4.1.24¹⁸-д зааснаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ нь тухайн шатны төсөвт хамаарах этгээдийн өмчлөлд бүртгэгдэх зарлага байдаг.

Мөн төсвийн төсөл боловсруулахад мөрдөгдөх эрх зүйн баримт бичигт тусгаснаар тэргүүлэх ач холбогдолтой, зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай,

¹⁸ 4.1.24."хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

тооцоо судалгаатай, уялдаа бүхий томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг нийслэлийн төсөвт тусган хэрэгжүүлэхээр байна.

Нийслэлд шинээр хэрэгжих 60,399.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 багц ТАХ-ээс 767.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ нь өмчид бүртгэгдэхгүй хөрөнгө оруулалтын бус шинж чанартай орон сууцны засвар, тооллого судалгаа, сургалтын зардал зэрэг ажил байна.

Хүснэгт 3. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ

№	ТАХ-ний нэр	Хугацаа		сая төг
		Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг
1	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын цахилгаан шат	2021 он	2021 он	150.0
2	Дээвэр засварын ажил /Сүхбаатар дүүрэг 1, 5, 6, 7, 10 дугаар хороо/	2020 он	2021 он	117.7
3	Нийтийн өмчийн авто замын нэгдсэн кадастрын зураглал бий болгож, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, хөдөлгөөний эрчмийн ээлжит тооллого судалгааны ажил	2021 он	2021 он	400.0
4	Инженер, техникийн ажилчдыг салбарын чиглэлээр мэргэшүүлэх, бэлтгэх	2021 он	2021 он	100.0
Нийт				767.7

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус зарим төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.

БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАХ-НИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ ЭСЭХ.

Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

НЗД 2021 онд харьяа 12 агентлагт 32 удаагийн захирамжаар 61,912.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 308 ТАХ-ний ХАА-ны эрхийг шилжүүлсэн.

Нийт 308 ТАХ-ээс 39,273.3 сая төгрөгийн төсөвтэй 261 ТАХ буюу 84.7%-ийн ХАА-г тухайн онд багтаан зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 4. ТАХ-ний худалдан авалт

№	Эрх шилжсэн байгууллага	НЗД-аас эрх шилжүүлсэн ТАХ				ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ			
		Захирамж	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Шалгарсан өртөг	Хэмнэлт
1	НХААГ	12	165	31,614.5	16,249.2	132	12,993.3	11,858.3	1,135.0
2	НЗХГ	4	54	12,586.6	12,346.6	49	11,290.8	10,855.7	435.1
3	УБЗАА	2	3	1,900.0	1,900.0	3	1,900.0	1,859.3	40.7
4	"УБЗЗА" ОНӨААТҮГ	4	55	10,430.1	10,266.1	54	8,266.1	8,196.1	70.0
5	БНД ХААА	1	2	963.6	522.7	2	963.6	488.1	475.5
6	БХД ХААА	2	3	199.6	199.6	3	199.6	198.7	0.9
7	ЗХУТ НӨҮГ	1	6	1,000.0	1,000.0	6	1,000.0	998.8	1.2
8	Зорчигч тээвэр-3 ОНӨААТҮГ	1	1	1,249.5	700.0	1	1,249.5	1,246.5	3.0
9	НД ХААА	1	1	550.4	550.4	1	550.4	540.0	10.4
10	НГЗБА	1	1	200.0	200.0	1	200.0	194.7	5.3
11	НЗДТГ	2	16	1,068.0	1,050.0	8	510.0	437.2	72.8
12	СХД ХААА	1	1	150.0	150.0	1	150.0	137.9	12.1
	Нийт	32	308	61,912.3	45,134.6	261	39,273.3	37,011.3	2,262.0

Харин 2021 онд 22,639.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 47 ТАХ дараах байдлаар хэрэгжиж дуусаагүй байна. Үүнд:

- 6,673.6 төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлсэн;
- 2,084.6 төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ тендерийн үнэлгээ хийгдэж байгаа;
- 8,171.0 төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ тендерийн материал хүлээн авч байгаа;
- 1,045.6 төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ тендерийн баримт бичиг боловсруулж байгаа;
- 4,664.0 төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ зураг төсөв, ажлын даалгаваргүй.

ТАХ-г төрлөөр авч үзвэл авто замын барилга байгууламж, өргөтгөл, шинэчлэлт, засвар, гүүр хоолой, тэмдэг тэмдэглэгээ 42.1%, зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ 36.0%, барилга, барилгын засвар, орчны тохижилт 13.9%, машин, техник, тавилга тоног төхөөрөмж 7.8%-ийг эзэлж байна. Хавсралт 3

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль, журмын мөрдөөгүйгээс зарим ТАХ тухайн онд хэрэгжээгүй, төлөвлөгөөт хугацаанд нь зохион байгуулаагүй, шаардлагад нийцээгүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан зэрэг зөрчил гаргасан байна.

Б.1.1 Төсөл арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн үү?

НИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 02/11 дугаар тогтоолоор нийслэлийн 2021 оны төсвийг баталж, 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн III-03/28 дугаар тогтоолоор тодотгосон байна.

НЗД-аас 2021 онд шинээр хэрэгжиж эхлэх 28,172.8 сая төгрөгийн төсөвтэй 71 ТАХ буюу 23%-ийг нь дээрх хугацаанд багтаан эрх шилжүүлсэн, харин 33,739.5 сая төгрөгийн төсөвтэй 237 ТАХ буюу 77.0%-ийг 4-214 хоногийн хугацаагаар хоцроож буюу 2021.02.04-2021.09.08-нд хүргэсэн байна.

Хүснэгт 5. НЗД-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа /хоногоор/

№	Эрх шилжсэн газрын нэр	ТАХ-ний Төсөвт өртөг /сая.төг/		Хоцроосон хугацаа
		Тоо	Төсөвт өртөг	
1	БНД	2	963.6	4
2	ЗТ-З ОНӨААТҮГ	1	1249.5	26
3	НД	1	550.4	4
4	НЗХГ	43	8,526.6	22-31
5	НХААГ	134	13,083.3	4-214
6	"УБЗЗА" ОНӨААТҮГ	54	8,266.1	51-155
7	УБЗАА	2	1,100.0	180
	Нийт	237	33,739.5	4-214

Сангийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн 102 дугаар тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг шинэчлэн баталсан. Тус журмаар төсөв батлагдсан болон тодотгол орсон үед мөрдөж байсан эрх шилжүүлэх хугацаа тусгаагүй байна.

НЗД 2021 оны 10 дугаар сараас 12 дугаар сар хүртэл 26,923.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 63 ТАХ эрх шилжүүлсний ихэнх хувийг автозамын шинэчлэлт өргөтгөл, автозамын засвар, дулааны шугам шинээр тавих, цахилгааны шугам шинээр тавих, орчны тохижилтын ажлууд эзэлж байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8¹⁹ дахь заалтыг зөрчсөн байна.

Хүснэгт 6. Хугацаа хоцорч эрх шилжүүлсэн ТАХ-ний төрөл

№	Төрөл	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	сая.төг
				ТАХ-ний эзлэх хувь
1	Авто замын барилга байгууламж, өргөтгөл, шинэчлэлт, засвар, гүүр хоолой, тэмдэг тэмдэглэгээ	19,155.8	109	46%
2	Барилга, барилгын засвар, орчны тохижилт	8,257.4	34	14%
3	Зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ	5,826.3	90	38%
4	Машин, техник, тавилга тоног төхөөрөмж	500.0	4	2%
	Нийт	33,739.5	237	100%

НЗД-аас хугацаа алдаж эрх шилжүүлсэн нь ТАХ-г хэрэгжих боломжтой хугацаандаа хэрэгжихгүй байх, ялангуяа барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай ажлууд хойшлогдох гэх мэт үр дагавартай байна.

Дүгнэлт: НЗД-аас хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлээгүй улмаас 22,639.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 47 ТАХ тухайн онд хэрэгжиж дуусаагүй байна.

¹⁹ 46.1.8.барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;

Б.1.2 Төсөл арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулсан уу?

Үнэлгээний хороо байгуулахтай холбоотой:

Эрх шилжсэн байгууллагууд нь ХАА зохион байгуулах 308 ТАХ-нээс 299 буюу 97.7%-ийн үнэлгээний хороо байгуулахад 60 хүртэл хоног зарцуулсан бол 2.3%-ийг байгуулахад 61-138 хүртэл хоног зарцуулжээ.

Хүснэгт 7. Үнэлгээний хороо байгуулсан хугацаа

№	ХАА зохион байгуулсан байгууллага	0-30 хоногт	30-60 хоногт	60-90 хоногт	90-ээс дээш хоногт	Нийт
1	БГД ХААА		1		1	2
2	БХД ХААА	2		1		3
3	ЗХУТ НӨҮГ	6				6
4	ЗТ-З ОНӨААТҮГ	1				1
5	НД ХААА			1		1
6	НЗХГ	52	2			54
7	НГЗБА	1				1
8	НЗДТГ	1	15			16
9	НХААГ	138	21		6	165
10	СХД ХААА	1				1
11	УБЗЗА ОНӨААТҮГ	55				55
12	УБЗАА	3				3
	Нийт	260	39	2	7	308

Үнэлгээний хороог 60-аас дээш хоногт байгуулсан нь захиалагчаас Төсвийн тухай хуулийн 29.4²⁰, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48.3²¹-т заасан үүргээ биелүүлээгүй, холбогдох баримт материалыг ХАА зохион байгуулах газруудад хууль тогтоомжид заасан хугацаанд хүргүүлээгүй зэргээс шалтгаалж байна. Тухайлбал НЗХГ, НХОГ нь 90-ээс дээш хоногт 22 ТАХ-тэй холбоотой ажлын техникийн тодорхойлолт, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг хугацаа хоцроож хүргүүлсэн байна. Хавсралт 4

Тендер зарлахтай холбоотой:

Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш 60 хүртэл хоногт нийт 277 буюу 89.9%-ийн ХАА-г зохион байгуулсан, 11.1%-ийг нь 61-ээс дээш хоногт зохион байгуулжээ.

Хүснэгт 8. Тендер зарласан ТАХ-ний тоо

	Хугацаа	Тах-ний тоо	Төсөвт өртөг /сая.төг/
1	0-30 хоногт	172	34,681.5
2	30-60 хоногт	105	13,849.3
3	60-90 хоногт	9	2,972.1
4	90-ээс дээш	22	10,409.4
	Нийт	308	61,912.3

Захиалагчаас ХАА зохион байгуулах байгууллагуудад 16,365.1 сая төгрөгийн төгрөгийн төсөвт өртөгтэй 58 ТАХ-ний техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай материалыг 2021 оны 10 дугаар сараас 2021 оны 12 дугаар сарын 21-ний хооронд ирүүлсэн зэрэг нь

²⁰ 9.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

²¹ 48.3.Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ.

үнэлгээний хороо байгуулах болон тендер оройтож зарлагдах шалтгаан нөхцөл болж байна. Улмаар ТАХ тайлант онд бүрэн хэрэгжих боломжгүйд хүрчээ.

Нийт 36 ТАХ-г ХАА нь оролцогч санал ирүүлээгүй, шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй зэрэг шалтгаанаар 2 болон түүнээс удаа дахин зарласан байна. Энэ нь захиалагчаас ХАА зохион байгуулахдаа тухайн тендер амжилтгүй болсон шалтгаан нөхцөлийг тодруулаагүй, техникийн тодорхойлолт, ТШӨХ, ажлын даалгавар, ажлын тоо хэмжээнд тохирох өөрчлөлтийг тухай бүрт хийгээгүй, ТБОНӨБАҮХАТХ-ийн 30.4.1²² заалтыг хэрэгжүүлээгүйтэй зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 9. Хойшлогдон зохион байгуулсан ТАХ-ний ХАА

Дахин зарласан шалтгаан	2-4 удаа зарласан	5-12 удаа зарласан
Оролцогч санал ирүүлээгүй	19 ТАХ	7 ТАХ
Шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй	17 ТАХ	2 ТАХ

Дүгнэлт: ТАХ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай материалыг ХАА-г зохион байгуулах байгууллагад хугацаа алдаж хүргүүлж байгаа нь ТАХ-г тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулж чадахгүйд хүргэж байна.

Б.1.3 Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгч шалгаруулсан уу?

2021 онд нийт 61,912.3 сая төгрөгийн төсөвтэй 308 ТАХ-ээс 39,273.3 сая төгрөгийн төсөвтэй 261 ТАХ буюу 84.7%-ийн ХАА-г тухайн онд багтаан зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан.

Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 13,092.1 төгрөгийн төсөвт өртөгтэй 42 ТАХ, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар 7,518.6 төгрөгийн төсөвт өртөгтэй 101 ТАХ, тендер шалгаруулалтын онцгой журмаар 9,376.5 төсөвт өртөгтэй 57 ТАХ, худалдан авах ажиллагааны хуулиар зохицуулагдахгүй ажил 9,286.1 төгрөгийн төсөвт өртөгтэй 61 ТАХ тендер зарласан байна.

Хүснэгт 10. ХАА-нд мөрдсөн журам /байгууллагаар/

сая.төг

№	ХАА зохион байгуулсан байгууллага	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам		Нээлттэй тендер шалгаруулалт т журам		Тендер шалгаруулалтын онцгой журам		Худалдан авах ажиллагааны хуулиар зохицуулагдахгүй ажил		Нийт	
		Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн
1	БНД ХААА	-	-	2	488.2	-	-	-	-	2	488.2
2	БХД ХААА	-	-	-	-	3	198.7	-	-	3	198.7
3	ЗХУТ НӨҮГ	-	-	-	-	-	-	6	998.9	6	998.9
4	ЗТ-З ОНӨААТҮГ	-	-	-	-	1	1,246.6	-	-	1	1,246.6
5	НД ХААА	-	-	1	540.0	-	-	-	-	1	540.0
6	НЗХГ	1	-	21	5,706.2	32	5,149.6	-	-	54	10,855.7

²² 30.4.1.тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;

7	НГЗБА	1	194.7	-	-	-	1	194.7		
8	НЗДТГ	1	-	-	14	417.9	1	19.3	16	437.2
9	НХААГ	120	6,739.9	27	3,907.8	18	1,210.5	-	165	11,858.3
10	СХД ХААА	-	1	137.9	-	-	-	1	137.9	
11	УБЗЗА ОНӨААТҮГ	-	-	-	-	55	8,196.1	55	8,196.1	
12	УБЗАА	-	2	1,095.0	1	764.3	-	3	1,859.3	

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.4²³-т заасны дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл буюу нийслэл, дүүргийн ЗДТГ-ын салбарын мэргэжилтнүүд, “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, ЗАА болон ИТХ-аас томилсон 31 иргэнийг оролцуулсан байна.

ХАА-ны ил тод байдлыг хангах хүрээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2²⁴-т заасны дагуу гэрээ хийгдсэн 39,273.3 төгрөгийн төсөвт өртөгтэй 261 ТАХ-нээс 29,047.2 төгрөгийн төсөвт өртөгтэй 197 ТАХ-г Төрийн Худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулжээ. Харин 940.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-г цаасаар хэлбэрээр зохион байгуулсан ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21.4, ЗГ-ын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.1.4.1-т заасан тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Хүснэгт 11. Цахим хэлбэрээр зарласан ТАХ

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг / сая.төг/	Төлөв	Зохион байгуулсан байгууллага	Тайлбар
1	Багахангай дүүргийн авто замын ус зайлуулах байгууламжийн ажил	50.0	Гэрээ хийгдсэн эн	БХД ХАА	НЗД-ийн 2021-11-10-ны өдрийн А/878 дугаартай захирамжаар ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34-р зүйлийн 34.1.5 дахь заалтыг үндэслэн гэрээ шууд байгуулах тухай захирамж гарсан.
2	Авто зогсоол (БХД)	90.0	Гэрээ хийгдсэн эн	БХД ХАА	НЗД-ийн 2021-11-10-ны өдрийн А/878 дугаартай захирамжаар ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34-р зүйлийн 34.1.5 дахь заалтыг үндэслэн гэрээ шууд байгуулах тухай захирамж гарсан.
3	Өвөлжилтийн бэлтгэл арга хэмжээ /8 багц ажил/	800.0	Гэрээ хийгдсэн эн	УБЗАА	НЗД-ын захирамжийн дагуу гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэсэн

Аудитаар 2021 онд ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгарсан 39,273.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 261 ТАХ-нээс 68.1% буюу 28,837.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 178 ТАХ-г түүвэрт хамруулан /НХААГ болон бусад СХД ХААА, БХД ХААА, НД ХААА, БНД ХААА, УБЗАА, НГЗБА-100%, ЗХУТ-84%, НЗХГ-52%, “УБЗЗА” ОНӨААТҮГ 47%/ шалгахад дараах зөрчлүүд илэрсэн.

1. ХАА-ны мэргэжлийн байгууллага НХААГ нь зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний 90 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж санхүүгийн саналын нээлтийг хийхдээ “Зөвлөхийн санал бэлтгэх зааварчилгаа”-ны 6.4²⁵-т заасныг зөрчсөн;

²³ 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутаг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

²⁴ 21.2.Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно.

²⁵ Техникийн доод оноог хангасан зөвлөхөд санхүүгийн саналыг нээх өдөр, цагийг албан бичгээр болон утсан холбоогоор мэдэгдэнэ. Энэ өдөр нь дээрх мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш таваас багагүй бөгөөд санал нээлтэд оролцох хүсэлтэй зөвлөхөд энэ боломжийг олгохуйц хоногийн дараа байна.

2. НХААГ-аас 475.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой заавар журмыг дагаж мөрдөөгүй;
3. НЗДТГ, УБ хотын ЗАА, НХААГ, НЗХГ, “УБЗЗА” ОНӨААТҮГ, СХД-ийн ХААА зэрэг газрууд 15,554.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 62 ТАХ-ний үнэлгээг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12.3-т заасан ТББ-т тусгасан санхүү, боловсон хүчин, техникийн чадавхи, тоног төхөөрөмж, туршлагын шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй, ТББ-т тусгасан шаардлага хангаагүй оролцогчдыг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан; Хавсралт 5
4. НЗД нийт 4 удаагийн захирамжаар “УБЗЗА” ОНӨААТҮГ-т 10,430.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 ТАХ эрх шилжүүлж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34-р зүйлийн 34.1.5²⁶-д заасан үндэслэлээр шууд гэрээ байгуулсан. Гэтэл “УБЗЗА” ОНӨААТҮГ нь дээрх ажлыг хэрэгжүүлэх туслан гүйцэтгэгч, мөн 6 төрлийн түүхий эд бараа материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хуулийн 34.2²⁷, 34.3²⁸-д заасныг дагаж мөрдөөгүй, 14-16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй 6 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.
5. НЗД 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Өвөлжилтийн бэлтгэл арга хэмжээ ТАХ-г 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр эрх шилжүүлснээс УБ хотын ЗАА нь уг тендерийг зарлахдаа төсөвт өртгийг үндэслэл болгоогүй, ХАА-ны журмыг буруу сонгосон, гэрээ шууд байгуулсан, цахимаар зарлаагүй зөрчил гаргасан.

Цаашид илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг үнэн зөвөөр үнэлэх, шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдлөгө болгон ажиллах, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: ХАА-г ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулсан ч шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.

Б.1.4 Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан уу?

2021 онд зохион байгуулсан ХАА-ны тайланг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.5²⁹, Сангийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу цахим болон цаасан хэлбэрээр 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/179 дугаар албан бичгээр хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлжээ.

²⁶ 34.1.5.гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол;

²⁷ Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

²⁸ Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

²⁹ 49.5.Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана

Харин УБ хотын ЗАА-наас ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгарсан 800.0 сая төгрөгийн өртөгтэй “Өвөлжилтийн бэлтгэл арга хэмжээ” ТАХ-г ХАА-ны жилийн эцсийн мэдээ тайланд тусгаагүй байна.

Дүгнэлт: ТАХ-ний ХАА-ны тайланг хугацаанд нь цахим болон цаасан хэлбэрээр тайлагнасан ч зарим мэдээг дутуу илэрхийлсэн байна.

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Өмнөх онуудаас дамжин хийгдсэн болон 2021 онд шинээр эхэлсэн 374,071.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 992 ТАХ-нд нийт 18 газраас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

2021 онд 113,929.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 727 ТАХ хэрэгжиж дууссан, 207,655.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 193 ТАХ дуусаагүй, 2022 онд үргэлжлэн хэрэгжиж байна. Харин 38,217.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 73 ТАХ тухайн онд хэрэгжиж эхлээгүй байна.

Нийслэлийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар өмнөх оноос дамжин хийгдсэн болон шинээр эхэлсэн 992 ТАХ-д захиалагчийн хяналт хэрэгжүүлэх 18 байгууллагыг томилон ажиллуулжээ.

Өмнөх онуудаас шилжих болон шинээр хэрэгжих 792 ТАХ-г тайланд онд дуусгаахаар баталжээ.

Зураг төсөвгүй батлагдсан, газрын байршил өөрчлөгдсөн, үнийн өсөлт зэргээс шалтгаалан 31,975.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан 9 ТАХ-нд 121,840.97 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө шаардагдсан байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2015-2020 онуудад хэрэгжүүлсэн 37,114.0 сая төгрөгийн дүнтэй 8 ТАХ газрын асуудал нь бүрэн шийдвэрлэгдээгүй, тухайн жилд санхүүжих дүнг бага хэмжээгээр тусгасан, /хэрэгжих хугацаанд тэнцүү хэмжээгээр тусгах заалтыг зөрчсөн/ түлхүүр гардуулах гэрээтэй ТАХ-ний зураг төсөл нь магадлалаар баталгаажихдаа төсөвт өртөг нь нэмэгдсэн, хөрөнгө санхүүжилтээс шалтгаалан дуусаагүй үргэлжилсэн, зарим барилгын ажил зогссон байна. Хавсралт 6

Захиалагчийн хяналтыг дүрмийн дагуу хэрэгжүүлэн, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч байгаа хэдий ч зураг төсөвгүй батлагдсан ТАХ-ний хөрөнгө хүрэлцэхгүй болох, төсөвт өртөг нэмэгдэх, мөн ковид-19 цар тахал зэргээс шалтгаалан дуусгаахаар төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.

Б.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гэрээний хугацаанд үр дүнтэй гүйцэтгэсэн үү?

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр өмнөх оноос дамжин болон 2021 онд шинээр эхэлсэн нийт 346,545.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 993 ТАХ-д “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, НЭМГ, НЗДТГ, ЗАА, НӨАУГ, НХБХГ, НГЗБА, НМТГ, ННТҮГ, ЗХУТ НӨҮГ, ГЦУГ, УБ-Лифт зэрэг газруудаас захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

Хүснэгт 12. ТАХ-ний гэрээний хэрэгжилт

№	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн	ТАХ-ний				Үүнээс					
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Гэрээний дүн	Хэрэгжиж дууссан		Дуусаагүй		2021 онд эхлээгүй	
						Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн
1	НХОГ	159	225,524.4	159	240,318.4	90	38,225.9	53	154,056.1	16	33,768.5
2	НЗХГ	703	111,621.4	703	100,680.2	545	53,477.4	125	44,639.2	33	2,563.6
3	НЭМГ	49	5,964.4	49	5,892.9	47	1,032.9	1	4,800.0	1	60.0
4	НБГ	22	328.7	-	-	-	-	-	-	-	-
5	НӨАУГ	8	177.9	8	177.9	8	177.9	-	-	-	-
6	ЗАА	3	902.1	3	884.2	3	884.2	-	-	-	-
7	УБ Лифт	1	150.0	1	150.0	1	150.0	-	-	-	-
8	ЗХУТ НӨҮГ	1	388.9	1	388.9	1	388.9	-	-	-	-
9	НГЗБА	3	6,898.2	3	6,892.9	1	5,698.6	2	1,194.3	-	-
10	НГЗБАУБГХХХО ДХ төсөл	1	272.9	1	272.9	1	272.9	-	-	-	-
11	НЗДТГ	15	1,000.0	15	805.8	-	-	-	-	15	805.8
12	НМТГ	1	798.7	1	798.7	1	798.7	-	-	-	-
13	ННТҮГ	8	24,340.0	8	1,519.7	1	500.0	-	-	7	1,019.7
14	НОСК	3	112.2	-	-	-	-	-	-	-	-
15	НХБХГ	31	3,499.5	31	3,360.2	19	394.0	12	2,966.2	-	-
16	НЦУГ	1	7,526.8	1	7,526.8	1	7,526.8	-	-	-	-
17	СХД	1	638.0	1	638.0	-	-	-	-	1	638.0
18	УБГХХХО ТХ төсөл	8	4,401.6	8	4,401.6	8	4,401.6	-	-	-	-
Нийт		1018	394,871.9	992	374,071.0	727	113,929.7	193	207,655.8	73	38,217.5

Дээрх ТАХ-нүүдээс 113,929.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 727 ТАХ буюу 73.2% нь хэрэгжиж дууссан, 207,655.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 193 ТАХ буюу 19.4% нь дуусаагүй он дамжин хэрэгжиж байна. Харин 38,217.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 73 ТАХ буюу 7.3% нь 2021 онд хэрэгжиж эхлээгүй байна.

НИТХ-ын 2021 оны III-03/28 дугаар тогтоолд өмнөх онуудаас шилжих 62,075.3 сая төгрөгийн 235 ТАХ, шинээр хэрэгжих 32,041.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 557 ТАХ 2021 онд дуусгахаар баталжээ. Үүний 70,714.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 686 ТАХ буюу 86.6% нь хэрэгжиж дууссан, 17,511.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 36 ТАХ буюу 4.6% нь хэрэгжиж дуусаагүй, 70 ТАХ буюу 8.8% нь эхлээгүй байна. Нийслэлийн төсвийн 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт ажил 67.0%-ийн гүйцэтгэлтэй байна.

Зураг төсөвгүйгээс шалтгаалан батлагдсан хөрөнгө хүрэлцэхгүй болох, төсөвт өртөг нэмэгдэх улмаар ТАХ-ний хэрэгжилт удаашрах, зогсох зэрэг сөрөг үр дагавар үүсжээ. Тухайлбал:

- Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын цогцолбор барилга: НИТХ-ын 2018 оны 4/13 дугаар тогтоолоор 17,394.4 сая төгрөгийн төсөвт өртөг анх батлагдаж, зураг төсөв магадлалаар батлагдахад 2019 онд 97,179.7 сая төгрөг, 2020 онд 127,935.4 сая төгрөг, анхны төсөвт өртөг 7.4 дахин нэмэгдсэн байна.
- 2018-2021 он дамжин хэрэгжсэн 9,586.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 5 ТАХ-ний гэрээ түлхүүр гардуулах нөхцөлөөр байгуулагдан зураг төсөв нь магадлалаар батлагдахад 10,534.9 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө, 4,111.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 ТАХ-нд газрын байршил өөрчлөгдсөн, үнийн өсөлт, хомсдолоос шалтгаалан 785.0 сая төгрөг, нийт 11,299.9 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө шаардагдаж төлөвлөсөн хугацаанд дуусах боломжгүй болсон. Хавсралт7

Аудитад 2021 онд хэрэгжиж дууссан 70,714.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 686 ТАХ-ээс түүвэрлэн 26,248.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 273 ТАХ-г хамруулан газар дээр нь ажлын тоо хэмжээ, зураг төсөвтэй тулган баталгаажуулалт хийсэн.

Гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотойгоор 6,072.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 ТАХ дуусаагүй байна.

“НХОГ” ОНӨААТҮГ захиалагч хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

- Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн баруун хэсгийн тохижилт /БЗД, 26 дугаар хороо/ төсөвт өртөг 717.9 сая төгрөг, гүйцэтгэгч Агар дүнз ХХК /ажил удааширч, технологийн шаардлагаар зогссон/
- Автобусны дулаан гаражийн барилга угсралтын ажил /Багц-1/, төсөвт өртөг 3,855.4 сая төгрөг, гүйцэтгэгч Хас дөл ХХК /төлөвлөсөн хугацаанд дуусах боломжгүй болсон/
- “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын харъяа баазын гаражуудын их засвар, агааржуулалт, төсөвт өртөг 1,499.0 сая төгрөг, гүйцэтгэгч Ди Вай Кэй Би ХХК /Зурагт орсон өөрчлөлтийг зохиогчоор баталгаажуулаагүй/

Харин захиалагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор 7,935.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 15 ТАХ гэрээний хугацаандаа хэрэгжиж дуусаагүй. Хавсралт 8

Аудитын явцад зарим төсөл арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэсэн эсэхийг холбогдох багаж тоног төхөөрөмж, баримт материалтай тулган баталгаажуулалт хийхэд захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж ажиллаагүй дараах зөрчил илэрсэн. Тухайлбал:

НЗХГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

- Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэг, хайс, тоноглолын засвар арчлалын ажил: **хурд сааруулагч, тэмдэглэл:** төсөвт өртөг 1,000.0 сая гүйцэтгэгч “УБЗЗА” ОНӨААТҮГ, /11 байршилд хийсэн ажлын 110.6 сая төгрөгийн төсөвт хурд сааруулагчийн 472 м2 тэмдэглэгээ арилсан/.
- Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажил. **Сургууль, цэцэрлэг орчмын явган хүний гарц, хурд сааруулагч.** Төсөвт өртөг 244.8 сая төгрөг гүйцэтгэгч УБЗЗА ОНӨААТҮГ, /19 байршилд хийсэн хурд сааруулагчийн 1071.47 м2 тэмдэглэгээ арилсан./ [12:05 PM] Enkhbayar:
- Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажил. Гол болон туслах гудамж замуудын хэвтээ тэмдэглэгээний ажил. Төсөвт өртөг 484.4 сая төгрөг гүйцэтгэгч УБЗЗА ОНӨААТҮГ, /5 байршилд явганы гарц 1881.4, 2 байршилд хурд сааруулагч 322.98 нийт 2204.3м2 тэмдэглэгээ арилсан./
- Хотын гол болон туслах гудамж замуудын засвар арчлалтын ажил Хотын гол болон туслах гудамж зам, уулзвар болон төвийн дүүргүүдийн орон сууцны хороолол доторх автозамын засвар. **Орон сууцны хороолол доторх авто замын засвар СБД.** Төсөвт өртөг 297.4 сая төгрөг, гүйцэтгэгч “УБЗЗА” ОНӨААТҮГ, /Зурагт тусгагдсан 22м зам талбайн (66 м2 асфальтбетон хучилт) хучилтын ажлыг зургийн авторын зөвшөөрөлгүй шилжүүлсэн.

Зураг 1. Бэлхийн авто зам, Цагаан худгийн буудлын шилэн самбар эвдэрсэн



Зураг 2. Автозамын тэмдэг, тэмдэглэгээ арилсан



Зураг 3. Орон сууцны 43А байрны гадна талын фасыг хэсэгчлэн хуурсан /НД дүүрэг/



НЭМГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

- Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний зориулалтын автомашин /40ш/. Төсөвт өртөг 4,800.0 сая төгрөг. Гүйцэтгэгч Моннис ХХК. Гүйцэтгэгчээс тээврийн хэрэгслийн дагалдах тоног төхөөрөмжүүдээс нэг бүр нь 25.9 сая төгрөгийн үнэтэй 40ш амьсгалын аппарат, 2.5 сая төгрөгийн дефибрилатор /Амгалан амаржих газарт/ нийт 1.0 тэр бум гаруй төгрөгийн хөрөнгө өнөөг хүртэл нийлүүлэгдээгүй. Түргэн тусламжийн төвд нийлүүлсэн 71-60 УАК улсын дугаартай автомашины серийн дугаар, 51-36 УАР улсын дугаартай автомашины арлын дугаар зөрсөн. Дагалдах хэрэгслээр тоноглогсон 4 хаалгатай 40ш тээврийн хэрэгсэл нийлүүлсэн нь техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтээс зөрүүтэй. Гаалийн бүрдүүлэлтийг үйлчилгээний зориулалттай автобус /бага оврын/ ангиллаар хийгдснээс ашиглагч байгууллагад татвар өндөр төлөгдөх, Д ангилалтай, мэргэшсэн жолоочтой болох гэсэн хүндрэлүүд үүссэн.



Зураг 5. Тусгай зориулалтаар тоноглогсон түргэн тусламжийн автомашин. Техникийн тодорхойлолтоос зөрүүтэй нийлүүлэгдсэн, тоног төхөөрөмж дутуу

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6³⁰-д дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гарсан зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

“НХОГ” ОНӨААТҮГ -аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

- Налайх дүүргийн ерөнхий боловсролын 109 дүгээр сургуулийн гадна талбайд Хөл бөмбөгийн талбай байгуулах /НД/ Төсөвт өртөг 118.7 сая төгрөг. Гүйцэтгэгч Номунзаяа ХХК. /Хөл бөмбөгийн талбайн зүлэг, хаалга хийгдээгүй, гэрээний хугацаа дуусаагүй/
- 6-9 дүгээр байрны дундах тохижилт /БНД, 1 дүгээр хороо/. Төсөвт өртөг 271.2 сая төгрөг. Гүйцэтгэгч Эм ти эм жи ХХК. /Тоглоом, гэрэлтүүлэг дутуу суурилуулагдсан, гэрээний хугацаа дуусаагүй/
- Орон сууцны 43А, 75, 79 дүгээр байрны гадна талын фасадыг хэсэгчлэн засварлаж, бүрэн будаж өнгө сэргээх /НД 5, 7, 8 дугаар хороо/. Төсөвт өртөг 108.9 сая төгрөг. Гүйцэтгэгч Үүлэн сүүдэр ХХК. /43А байрны гадна фасадны будаг хуурсан/
- Нийслэлийн Улаанбаатар чуулгын тайзны засвар Төсөвт өртөг 68.2 сая төгрөг. Гүйцэтгэгч Бун бах ХХК. / Ажлын нэр төрөл тоо хэмжээ өөрчилсөн, өөрчлөн гүйцэтгэсэн, зарим хэсгийн будаг арилсан/.
- Өргөө амаржих газрын барилгын их засвар /СБД 1-р хороо/ Төсөвт өртөг 69.7 сая төгрөг. Гүйцэтгэгч Жавхлант богд ХХК. /Явган хүний замын хавтанг тэгш бус тавьсан/

³⁰20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

- Нийслэлийн түргэн тусламжийн төвийн автобаазын их засвар /СБД 6-р хороо// Төсөвт өртөг 59.1 сая төгрөг. Гүйцэтгэгч Батстрой ХХК. /Дотор зогсоолын зарим хэсгийн резинэн будаг ховхорсон /.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Барилгын тухай хуулийн 14.7³¹, Барилга, байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.7³², Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6³³-д дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гарсан зөрчлийг арилгах, эвдрэл гэмтлийг засуулах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Нийслэлийн төсвийн 2019-2021 онуудад хийгдэж байгаа 1 ТАХ-ний гэрээнд заасан хугацаа хэтэрсэн боловч гэрээний заалтын дагуу алданги тооцож ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3³⁴, Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1³⁵, Барилгын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6³⁶ дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

“НХОГ” ОНӨААТҮГ захиалагч хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

Автобусны дулаан гаражийн барилга угсралтын ажил /Багц-1/. 3,855.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, гүйцэтгэгч Дөл ХХК, хэтэрсэн хугацаа 60 хоног; Уг зөрчлийг давтан гаргахгүй байх, гэрээ дүгнэн, хэтэрсэн хоногт алданги тооцуулах албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийслэлийн ЗДТГ захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

“Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор” шинэ байранд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудыг шилжүүлэн байршуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын зардал **Хуралдааны танхимуудын аудио удирдлагын тоног төхөөрөмж** 56.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, гүйцэтгэгч Глобалсмайт сольюшн ХХК. /НЗДТГ-ын холбогдох хэлтсүүдийн уялдаа холбоо, ажил хариуцсан албан тушаалтны хариуцлаггүй байдлаас шалтгаалан хугацаа алдсан/

“Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор” шинэ байранд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудыг шилжүүлэн байршуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын зардал **Өрөө тасалгаануудын хөшиг, эд хэрэгсэл** 19.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, гүйцэтгэгч Эмералд сийд ХХК. /НЗДГ-аас хөшигний өнгөний сонголтыг тавилга хийгдсэний дараа хийнэ гэсний дагуу гүйцэтгэгч ажлаа дуусгаж хүлээн өгөхөд хугацаа алдсан/

Нийтийн эзэмшлийн зам талбайд 1,996.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үйл ажиллагааг хариуцан явуулах ашиглагч байгууллага тодорхойгүйгээс одоог хүртэл ашиглалтгүй, гүйцэтгэгч харуул хамгаалалтын асуудлыг хариуцаж байна. Үүнд,

Тахилт, Цагдаа толгой орчимд цэцэрлэгт хүрээлэн байгуулах /СХД, 22 дугаар хороо/. Төсөвт өртөг 1,996.1 сая төгрөг. УКА 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн ЗТ-116/2021 дугаартай баталгаажсан боловч ашиглагч байгууллага байхгүйгээс хөрөнгө тоногдох, эвдрэх зэрэг нөхцөл бүрдэхээр байна.

³¹14.7.Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна.

³²3.7. Ашиглагч барилга байгууламжид хийсэн үзлэгээр илэрсэн эвдрэл гэмтлийг тухай бүр цаг алдахгүй арилгуулах арга хэмжээ авна.

³³20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

³⁴5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;

³⁵350.1.1.гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх;

³⁶Барилгын тухай хуулийн 3.6-д Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана.

Зураг 6. Цагдаа толгойн цэцэрлэгт хүрээлэн. Ашиглагч байгууллага нь тодорхойгүй



Цэцэрлэгт хүрээлэнгийн барилга байгууламжийн ашиглагч байгууллагыг тодорхой болгон эзэнжүүлэх шаардлагатай байна.

Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрмийн 8.1³⁷, 8.2³⁸, 8.2.1³⁹ 8.2.2⁴⁰-д заалтыг мөрдөөгүй байна. Захиалагч, гүйцэтгэгч талууд техникийн комиссоор илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгах үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүйгээс зарим барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргах ажил удааширсан байна. Тухайлбал:

- Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо 72 дугаар хотхон орчмын ашиглалтын шаардлага хангахгүй 5, 16, 24 дүгээр байруудыг дахин барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил /1 дүгээр ээлж/. Гүйцэтгэгч Тунгалагбуянт Дуут ХХК болон Вивазоне ХХК-иудын түншлэл, гэрээний дүн 764.4 сая төгрөг.
- Эрдмийн оргил цогцолборын төв сургуулийн гадна дулааны шугамын засвар /НД, 2 дугаар хороо/. Гүйцэтгэгч Зана констракшн ХХК, гэрээний дүн 64.0 сая төгрөг.
- 176 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын халаалтын засвар /СХД, 31 дугаар хороо/. Гүйцэтгэгч Зана констракшн ХХК, гэрээний дүн 28.0 сая төгрөг.
- “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын харьяа баазын гаражуудын их засвар, агааржуулалт. Гүйцэтгэгч Ди Вай Кэй Би ХХК, гэрээний дүн 1,498.9 сая төгрөг.

Үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй дээрх ТАХ-д техникийн комиссыг дахин ажиллуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Барилгын тухай хуулийн 37.6-д дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно гэж заасан. Гэтэл нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим барилга байгууламжийг Барилга байгууламж ашиглалтад оруулах дүгнэлт гараагүй байхад ашиглаж эхэлсэн байна. Тухайлбал:

³⁷8.1. Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.

³⁸ 8.2. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн 8.1-д заасан хугацаанд багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

³⁹8.2.1. барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт;

⁴⁰ 8.2.2. энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт.

- **Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын цогцолбор барилга А блок.** Нийслэлийн Засаг даргын дэргэдэх зарим агентлагууд шилжиж орсон. /ЗГ-ын 2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн Нийслэлийн нутгийн удирдлагын байгууллагуудыг шилжүүлэн байршуулах тухай 282 дугаар тогтоолоор НИТХ, ЗДТГ, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлагуудыг 2021 оны 12 дугаар сард багтаан ээлж дараатайгаар шилжүүлэн байршуулахыг Нийслэлийн Засаг даргад даалгасан/.

Зураг 4. Нутгийн захиргааны байр А блок.
Улсын комиссыг акт баталгаажуулж, ашиглаж эхэлсэн



- **Тахилт 1-12 дугаар гудамж орчмын айл өрх /СХД, 22 дугаар хороо /Ажил бүрэн дууссан, санхүүжилтээс шалтгаалж УКА баталгаажуулж, ашиглаж эхэлсэн. УИХ-ын гишүүн, ЭХЯ-ны айл өрхийг цахилгаанд холбох хүсэлтийн дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК цахилгаан эрчим хүчинд холбох зөвшөөрөл олгосон/**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлууд чанаргүй, эвдэрч тоногдсон, эзэнгүйтсэн, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй, хяналт сул, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцдоггүй зэрэг нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Дүгнэлт: Гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотойгоор 16,234.7 сая төгрөгийн 16 ТАХ-ний гэрээний хэрэгжилт бүрэн хангагдаагүй байгаа нь захиалагчийн хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Б.2.2. Эрх бүхий этгээд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн үү?

Барилгын тухай хуулийн 2.1-д захиалагчийн үйл ажиллагаа нь Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан зарчмыг хэрэгжүүлж, шаардлагыг хангуулахад чиглэгдэх бөгөөд барилга байгууламж барих нөхцөлийг бүрдүүлэх, оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хяналт тавих замаар хэрэгжинэ гэж заасан.

Нийслэлийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих 88,226.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 722 ТАХ-г 2021 онд дуусгах гэрээ байгуулж, НЗД-ын захирамжаар захиалагчийн хяналт тавьж ажиллах 18 байгууллагыг томилжээ. 2021 онд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх 563 ТАХ-г төрлөөр авч үзвэл 77.4% буюу 436 ТАХ зам зогсоол, тэмдэг тэмдэглэгээ, 9.6% буюу 54 ТАХ тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 8.0% буюу 45 ТАХ барилга угсралт, засвар, инженерийн шугам сүлжээ, 4.8% буюу 21 ТАХ зураг төсөл, судалгааны ажил, 0.2% буюу 1 ТАХ нөхөр олговор эзэлж байна.

ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2⁴¹-т захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулж болохоор заажээ. Нийслэлд хэрэгжиж байгаа ТАХ, үүний дотор авто зам, гүүр, барилга, байгууламжийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий НЗХГ /дүрмийн 3.2⁴²/, “НХОГ” ОНӨААТҮГ /дүрмийн 4.3.1⁴³/, хэрэгжүүлж байна.

Барилга байгууламж, зам, засвар, шугам сүлжээ, зураг төсөл зэргээс бусад нь /тавилга эд хогшил, техник тоног төхөөрөмж/ ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх тухайн шатны мэргэжлийн байгууллагууд хяналт хэрэгжүүлсэн байна.

Дүгнэлт. Барилга захиалагчийн дүрмийн дагуу эрх бүхий байгууллага захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Б.2.3. ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлсэн үү?

ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.10⁴⁴-д захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажил болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн актыг барилгын үйл ажиллагаанд оролцогчидтой хамтран сар бүр хянан баталгаажуулна гэж заажээ.

ЗГ-ын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.9⁴⁵-д заасны дагуу захиалагч нь үе шатны ажилд хяналт хэрэгжүүлэхдээ ил далд ажлын акт, холбогдох баримт материалыг, графикт хугацаа, гэрээний дагуу хянаж баталгаажуулсан эсэхийг 14,667.0 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 35 ТАХ хамруулан үзлээ.

Захиалагчаас ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахдаа ил далд ажлын актууд, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэлүүд, холбогдох бусад баримт бичгийг үндэслэж байна. Дээрх 35 ТАХ-ний хүрээнд давхардсан тоогоор туршилт тохируулга хийсэн болон ил далд ажлын 277 төрлийн 337 актыг холбогдох албан тушаалтнууд /захиалагч, зохиогч, гүйцэтгэгчийн төлөөлөл, инженерүүд/ баталгаажуулжээ. Хавсралт 9

Хүснэгт 13. Гүйцэтгэлийн шатанд баталгаажуулсан актууд

Туршилт тохируулга хийсэн акт		Далд ажлын актууд		Ил ажлын актууд	
Төрөл	Тоо	Төрөл	Тоо	Төрөл	Тоо
50	81	114	124	113	132

Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын инженерүүд барилгын ил далд ажлын акт зэргийг тухай бүр хянан ажилласан байна.

⁴¹ 2.2.Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

⁴² 3.2. нийслэлийн авто замын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд авто зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөн шинэчлэх, урсгал засвар, ашиглалт, арчлан хамгаалалтын ажлыг зохион байгуулж, захиалагчийн болон лабораторийн хяналт тавих, ашиглалтад хүлээлгэн өгөх;

⁴³ 4.3.1-т үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь улс, нийслэлийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хөрөнгөөр барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр хяналт тавих

⁴⁴ Захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажил болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилт зэрэг холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө (график), гэрээнд заасны дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчидтой хамтран сар бүр хянан баталгаажуулна

⁴⁵ 3.9.Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

Дүгнэлт: Захиалагч үе шатны хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Б.2.4 Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн үү?

Аудитаар 2021 онд хэрэгжүүлсэн 14,677.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 35 ТАХ-г хэрэгжүүлэх явцад захиалагч, зураг төсөв зохиогч, холбогдох мэргэжлийн байгууллагууд хяналт хэрхэн тавьсан, гүйцэтгэгч илэрсэн зөрчил дутагдлыг хугацаанд биелүүлсэн эсэхийг талбайн журнал болон холбогдох бусад баримт материалын хүрээнд үзлээ.

Барилга байгууламжийн талбайн журналд тэмдэглэгдсэнээр ТАХ-ний хэрэгжилтийн явцад давхардсан тоогоор НХОГ-ийн хяналтын инженерүүдээс 207 удаагийн, зураг төсөв зохиогч нараас 131, мэргэжлийн байгууллагуудаас /НМХГ/ 42, нийт 380 удаагийн үүрэг даалгавар өгчээ. Үүрэг даалгаврын агуулгаас харахад хөдөлмөр хамгааллыг сахиж ажиллах, үе шатны ажлыг технологийн дагуу хугацаанд нь гүйцэтгэх, дутуу болон чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийх, үе шатны ажлыг гүйцэтгэж дуусахад актуудыг холбогдох албан тушаалтнуудаар заавал баталгаажуулж байх, сорьц дээж авч лабораторид туршилт хийлгүүлэх зэрэгт чиглэгдсэн байна. Хавсралт 10

Гүйцэтгэгчдээс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлснээр ил далд ажлын актыг цаг тухай бүр захиалагч, зохиогч нараар баталгаажуулсан, ажлын гүйцэтгэл, ил болон далд ажлуудыг фото зургаар баталгаажуулж хэвшсэн байна. Мөн графикт ажлыг хугацаанд нь гүйцэтгэх, гэрээнд заасан хугацаанд багтаан дуусах зэрэгт ахиц гарсан байна. Тухайлбал: 2021 онд 792 ТАХ хэрэгжиж дуусгах гэрээ байгуулснаас захиалагчаас шалтгаалж хугацаандаа дуусаагүй 15 ТАХ байгаа бол гүйцэтгэгчээс шалтгаалсан 3 ТАХ байна.

Дүгнэлт: Илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр тухай бүрд нь арилгуулах арга хэмжээг авч ажилласан байна.

Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна уу?

НИТХ-аас баталсан тогтоолд нийслэлийн хэмжээнд он дамжих болон шинээр хэрэгжих 175 багц ТАХ-нд 2021 онд нийт 145,990.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 99,903.9 сая төгрөг олгосон байна. 2021 онд хэрэгжиж дууссан 83 ТАХ-нээс 3,133.6 сая төгрөгийн өртөг бүхий 17 ТАХ-г хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна.

Б.3.1. ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон уу?

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр шинэ болон шилжих 130 ТАХ-нд тайлант онд /363 гүйцэтгэгч байгууллага/ 115,021.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 349 гүйцэтгэгчид 87,733.6 сая төгрөг буюу 76.0%-ийг санхүүжилт олгожээ.

Хүснэгт 14. ТАХ-ний санхүүжилт

№	Санхүүжилт олгосон байгууллага	ТАХ-ний			Үүнээс:			сая.төг
		Тоо	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн	Тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	
1	ЗАА	3	902.1	352.1	3	884.2	324.2	
2	ЗХУТ НӨҮГ	1	388.9	163.7	1	388.9	163.7	
3	НЗХГ	191	111,621.4	60,151.2	187	98,712.1	42,955.9	
4	НБГ		328.7	328.7		-	-	

5	НГЗБА	2	6,898.2	6,198.6	2	6,698.2	5,997.4
6	НГЗБА	1	272.9	272.9	1	272.9	272.9
	УБГХХОДХ Төсөл						
7	НЗДТГ	1	1,000.0	1,000.0	1	1,000.0	1,000.0
8	НМТГ	1	798.7	336.3	1	798.7	336.3
9	ННТҮГ		1,290.0	1,180.0		-	-
10	НОСК ХК	3	112.2	112.2	3	108.4	-
11	НӨАУГ	1	177.9	87.9	1	177.9	87.9
12	НТҮГ	1	23,050.0	500.0		23,050.0	-
13	НХБХГ	19	3,499.5	1,230.8	19	3,360.2	1,189.1
14	НХОГ	120	277,552.2	36,227.1	111	269,016.7	28,698.2
15	НЦУГ	1	7,526.8	1,000.0	1	7,526.8	1,000.0
16	НЭМГ	9	5,964.4	1,789.8	9	5,882.7	1,708.1
17	УБ Лифт НӨҮГ	1	150.0	150.0	1	137.9	134.3
18	УБГХХОДХТөсөл	8	4,401.6	3,865.6	8	4,401.6	3,865.6
19	Захирамж гараагүй		105.5	75.0		-	-
	Нийт	363	446,041.0	115,021.9	349	422,417.2	87,733.6

Харин он дамжин санхүүжих ТАХ-ний 45 ТАХ-нд /255 гүйцэтгэгч байгууллага/ тухайн онд санхүүжих 30,969.1 сая төгрөгийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 12,170.3 сая төгрөг буюу 39.0%-ийн санхүүжилт олгожээ.

Санхүүжилтийг олгохдоо техник хяналтын зардалд 1,496.7, барьцаа хөрөнгийн дансанд 4,698.6, алдангид 60.0, зураг төсвийн зардалд 250.3, зохиогчийн хяналтын зардалд 283.0, норм нормативын зардалд 168.7 төгрөг тооцож олгожээ.

ЗГ-ын 2021 оны 09 дүгээр сарын 8-ны “Нийслэлийн нутгийн удирдлагын байгууллагуудыг шилжүүлэн байршуулах тухай” 282 дугаар тогтоолоор “Нутгийн захиргааны байгууллагуудыг ээлж дараатайгаар нүүлгэн байршуулах тухай” НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт даалгасан байна.

Дээрх ажлын 2021 онд тухайн жилд зарцуулагдаагүй санхүүжилтийн үлдэгдэл 1 ТАХ-ний 1,000.0 сая төгрөгийг НЗДТГ-ын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7⁴⁶, 43.5⁴⁷, 45.2⁴⁸-д заасан төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлэх, ТБОНӨХБАҮХАТХ-д заасан барьцаа хөрөнгийн дансанд гэрээний үнийн дүнгийн 5-10%-ийг байршуулж болох заалтыг зөрчиж байна.

Аудитаар санхүүжилт олгохдоо бодит гүйцэтгэлд үндэслэсэн эсэхийг шалгахад илүү олгосон зөрчил илрээгүй, харин 7,758.0 сая төгрөгийн дүнтэй 9 ТАХ-нд санхүүжилтийг олгохдоо бодит гүйцэтгэлээс дутуу олгосон байна.

Хүснэгт 15 . Бодит гүйцэтгэлд үндэслээгүй дутуу санхүүжилт олгосон ТАХ

сая.төг						
№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Гэрээний дүн	Олгосон нийт санхүүжилт	Санхүүжилтийн хувь	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
1	Цэцэрлэгийн барилга 100 ор /БНД, 4 дүгээр хороо, Байдлаг хэсэг/	1,688	550.0	52%	100%	2022 онд дууссан
2	Цэцэрлэгийн барилга худалдан авах 100 ор /БЗД, 25 дугаар хороо/	1,200	650.0	54%	100%	2020 онд дууссан
3	15 дугаар сургуулийн спорт заалны барилга /ХУД, 3 дугаар хороо/	700	350.0	50%	100%	2021 онд дууссан
4	Жишиг өрхийн эмнэлгийн барилга /ЧД, 1, 2, 3 дугаар хорооны дунд үйлчлэл/	1,170	550.0	47%	75%	Ажил үргэлжилж байгаа

⁴⁶ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

⁴⁷ Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.

⁴⁸ Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ.

5	24 дүгээр байрны барилгын фасад /БГД, 6 дугаар хороо/	713	628.0	88%	100%	2021 онд дууссан
6	Малтай фермтэй айлуудын урд, Баянгийн давааны хойд хэсгийн айл өрх /СХД, 21 дүгээр хороо/	331	81.0	24%	50%	Ажил үргэлжилж байгаа
7	Баянхайрханы гудамжны айл өрх /СХД, 24 дүгээр хороо/	132	50.0	38%	78%	Ажил үргэлжилж байгаа
8	Ар согоот, Зунжингийн зүүн хойд талын айл өрх /ЧД, 19 дүгээр хороо/	325	90.0	28%	50%	Ажил үргэлжилж байгаа
9	“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын харъяа баазын гаражуудын их засвар, агааржуулалт	1,499	700.0	47%	90%	Ажил үргэлжилж байгаа
Нийт		7,758	3,649.0			

Бүрэн хэрэгжиж дууссан БНД, БЗД-т ашиглалтад орсон цэцэрлэг, ХУД-ийн 15 дугаар сургуулийн спорт заалны барилга зэрэг 3 ТАХ, ажил хэвийн үргэлжилж байгаа СХД-ийн Баянхайрханы айл өрхийн цахилгаан хангамж, ЧД-ийн Ар согоот, Зунжингийн зүүн хойд талын айл өрх цахилгаан хангамж зэрэг 6 ТАХ-ний санхүүжилтыг гүйцэтгэлийн хувиас бага санхүүжилт олгожээ.

Энэ нь Ковид-19 цар тахалын үед баталсан УИХ 2020 оны 21 дүгээр тогтоолоор цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөхөөр шийдвэрлэсэн. Үүнтэй холбогдуулж Нийслэлийн төсвийн орлого бүрдүүлэлт багасч төсөв хүндэрсэнтэй холбоотой байна.

Дүгнэлт: Он дамжих болон шинээр хэрэгжих 175 багц ТАХ-нд 2021 онд нийт 145,990.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 99,903.9 сая төгрөг олгосон байна. Зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс дутуу олгосон байна.

Б.3.2. Ашиглалтад орсон барилга байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна уу?

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2⁴⁹ дагуу төсвийн хөрөнгө оруулалт нь төрийн болон орон нутгийн өмч байна.

НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.1⁵⁰-т зааснаар хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжсэн хуулийн этгээдийн тайлан баланст бүртгэдэг байна.

Нийслэлийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгө бүртгэж авахыг даалгасан 50 удаагийн захирамжаар 582 ТАХ-г НӨАУГ бүртгэхээр байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн ТАХ-ээс НӨАУГ-ын шийдвэрээр ашиглагч байгууллагад бүртгэх 17,183.0 сая төгрөгийн өртөг бүхий 82, /үүнээс тухайн онд 3,133.6 сая төгрөгийн өртөг бүхий 17 ТАХ-г хөрөнгийн бүртгэсэн/ ашиглагч байгууллагууд өөрсдөө шууд бүртгэх 2,533.4 сая төгрөгийн өртөг бүхий 44, өмчид бүртгэгдэхгүй хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 14,756.1 сая төгрөгийн

⁴⁹ 6.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

⁵⁰ “Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын гадаад дотоодын зээл төсөл хөтөлбөр, буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг тухайн төсөл хэрэгжүүлсэн хуулийн этгээдийн тайлан балансад бүртгэнэ”

өртөг бүхий 132 ТАХ, 2022 он руу дамжин хэрэгжих 15,506.7 сая төгрөгийн 23 ТАХ байна. Хавсралт 11

Бусад ажлуудын хувьд техникийн баримт бичгийн бүрэн хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах, тогтоол гаргах зэргээр 2022 онд бүртгэгдэхээр байна.

НӨАУГ-аас ирүүлсэн бүртгэлийн мэдээллийг судлахад 14,756.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 132 ТАХ нь нийслэлийн өмчид бүртгэхгүй хөрөнгө байна. Үүний 12,346.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 ТАХ нь замын тэмдэг, нөхөөс, 2,410.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 49 ТАХ нь барилгын фасад засвар, гэрэлтүүлгйн ажил байна.

Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн ашиглалтын байдалтай газар дээр нь танилцахад бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй зарим зөрчил илэрсэн.

Ашиглагч байгуулагад хүлээлгэн өгсөн 541.3 сая төгрөгийн хөрөнгө тоногдож эвдэрсэн. Үүнд:

- Сагсан бөмбөгийн талбайн тохижилт /НД, 1 дүгээр хороо/ Төсөвт өртөг 78.3 сая төгрөг. /1ш сандал, 1ш хогийн сав, 2ш гэрэлтүүлэг асалт бүрэн биш, хашааны тор гагнаас салсан/
- Сагсан бөмбөгийн талбайн тохижилт /НД, 2 дугаар хороо/ Төсөвт өртөг 75.2 сая төгрөг. /1ш сандал, 2ш кольцо тоногдсон/
- Сагсан бөмбөгийн талбайн тохижилт /НД, 4 дүгээр хороо/ Төсөвт өртөг 73.9 сая төгрөг. /1ш сагсны шийдний самбар хагарсан, хашааны тор гагнаас салсан, хогын савны 4ш дотор сав алдагдсан/
- Сагсан бөмбөгийн талбайн тохижилт /НД, 6 дугаар хороо/ Төсөвт өртөг 74.3 сая төгрөг. /4ш гэрэлтүүлэгийн гэрэл алдагдсан, хашааны тор гагнаас салсан/
- Сагсан бөмбөгийн талбайн тохижилт /НД, 7 дугаар хороо/ Төсөвт өртөг 79.6 сая төгрөг. /Сагсны шийдний 2ш самбар хагарсан, 1ш кольцо алдагдсан, гэрэлтүүлэгийн асалт бүрэн биш, хашааны хаалга эвдэрсэн/
- Сагсан ө

Аудитын явцад илэрсэн 6,931.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний зөрчлийг арилгуулсан. Тухайлбал:

- СХД-ийн Нутгийн захиргааны нэгдсэн байрны барилга. Төсөвт өртөг 6,822.4 сая төгрөг, Тус барилгын лифт ашиглагчаас шалтгаалан ажиллахгүй байсан.
- Орон сууцны 43А, 75, 79 дүгээр байрны гадна талын фасадыг хэсэгчлэн засварлаж, бүрэн будаж өнгө сэргээх /НД 5, 7, 8 дугаар хороо/. Төсөвт өртөг 108.9 сая төгрөг. 43А байрны гадна фасадны будаг хуурсан байсныг дахин гүйцэтгүүлсэн.

Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн ашиглалтын байдалтай газар дээр нь танилцахад бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй зарим зөрчил илэрсэн. Тухайлбал:

ХУД-ийн нэгдсэн эмнэлэгт нийлүүлсэн 67,7 сая төгрөгийн дүнтэй “Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж” ашиглалт хангалтгүй.

- “Хэвлийн хөндийн мэс заслын иж бүрдэл” нь Ковидын үеийн хөл хорионы үед улаан бүсийн түвшиний үед мэс ажилбар хойшлуулсан, эмнэлэг энгийн дэглэмд шилжиж хэвийн ажиллах үед ашиглана.
- Дефиблятор аппарат ашиглалт агуулахад хадгалагдаж байна.

Иймд дээрх зөрчлүүдийг арилгах, ашиглалтгүй байгаа хөрөнгийг эзэнжүүлэн ашиглалтыг сайжруулах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: 2021 онд хэрэгжиж дууссан 17 ТАХ-г хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна. Зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй байсныг аудитын явцад зөрчлийг арилгуулсан.

Б.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг арилгасан уу?

“Нийслэлийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” аудитаар НИТХ 2, НЗД 4, “УБЗЗАА” ОНӨААТҮГ 1, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ 1, нийт 7 зөвлөмж хүргүүлсэн. Мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабазар, НЗДТГ-ын дарга Т.Оюунчимэг нарт төлөвлөлт, эрх шилжүүлэх, худалдан авалт, гэрээний хэрэгжилттэй холбоотой зөрчил арилгуулах тухай НТАГ-ын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 377/АО270195, АО270197 дугаартай 1 албан шаардлагыг хүргүүлсэн. Үүнээс 3 зөвлөмж болон албан шаардлага хэрэгжээгүй байна. Үүнд:

- Зөвлөмж: НИТХ-д хүргүүлсэн “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын жагсаалтад нэр, газрын байршил, зөвшөөрөл, зураг төсөвтэй буюу төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг эх үүсвэрээс нь үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр нь тусган баталж байх” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. 2021 оны хөрөнгө оруулалтын ажлын жагсаалт батлахдаа 22 төсөл арга хэмжээг ерөнхий нэрээр, зураг төсөв шаардлагатай түүвэрт хамрагдсан 12 ТАХ-ний зураг төсвийг төсөв баталсны дараа боловсруулсан байна;
- НЗД-д хүргүүлсэн “Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэхдээ Нийслэл, дүүргийн эрх бүхий худалдан авах ажиллагааны нэгжид шилжүүлж байх” зөвлөмж хэрэгжээгүй, мэргэжлийн бус 6 байгууллагад эрх шилжүүлсэн;
- “УБЗЗА”, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-д хүргүүлсэн “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн актуудыг бүрэн мөрдөх” зөвлөмж хэрэгжээгүй, “УБЗЗА” ОНӨААТҮГ нь 6 төрлийн түүхий эд бараа материал нийлүүлэх, туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль тогтоомжийг мөрдөөгүй зэрэг зөрчил дахин давтагдаж байна.

Албан шаардлага: НЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 03/5486 дугаар Албан шаардлагын хариу хүргүүлэх тухай албан бичгээр албан шаардлагатай танилцан хариу тайлбар ирүүлэхдээ алдаа, зөрчлийг хэрхэн таслан зогсоосон талаар биелэлт ирүүлээгүй. Тухайлбал:

- “Хүүхдийн сургуулийн автобус нийлүүлэх” нийлүүлэх ажлын ажлын гэрээнд заасан 2020 онд нийлүүлээгүй 70ш автобусыг хүлээн авч, алданги тооцох, гэрээний биелэлтийг бүрэн хангуулах, автобусны үнэлгээг дахин хянах, захиалагчийн үе шатны хяналтыг хэрэгжүүлэх гэсэн алдаа зөрчлийг арилгуулсан эсэх нь тодорхойгүй;
- Өмнөх аудитаар шалгахад ажил гүйцэтгэх гэрээнд бараа нийлүүлэх тоо, хугацаа, нийлүүлэлт хуваарь, санхүүжилтийн хэлбэрийг нарийвчлан тусгаагүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын эрх үүргийг тодорхой бус захирамжилснаас захиалагч, гүйцэтгэгчийн ажлын хариуцлага алдагдаж, нийлүүлэлт удааширсан байсан. Үүний шалтгааныг тодруулахад 1 ш хүүхдийн автобусны 307,3 сая төгрөгийн үнэлгээг төлөвлөсөн тооцоолол, төсөв нотлох баримт холбогдох байгууллагуудад байхгүй бөгөөд гэрээнд тусгасан хүүхдийн автобусны нэгжийн үнэлгээ 307,3 сая төгрөг нь гаалийн мэдүүлгийн үнэлгээ 133,1 сая төгрөгөөс 174.2 сая төгрөгөөр буюу үнэлгээний зөрүү их байгаа шалтгааныг тооцоолох боломжгүй байсан. Иймд 70 ширхэг автобусыг хүлээн авч, алданги тооцох, гэрээний биелэлтийг бүрэн хангуулах, 1 ширхэг автобусны үнэ 307.3 сая төгрөгийн үнэлгээ анхан шатны баримтаар нотлогдоогүй тул дахин хянаж, захиалагчийн үе шатны хяналтыг хэрэгжүүлэх албан шаардлага өгсөн.
- Шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан, ХАА зохион байгуулсан албан хаагчдад хариуцлага тооцох гэсэн алдаа зөрчлийг арилгуулсан эсэх тодорхойгүй,

Аудитаар илэрсэн зөрчил, үр дүнгээс харахад эрх бүхий хэрэгжүүлэгч агентлагуудад хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилт, ХАА-нд хууль эрх зүйн дүрэм журмыг бүрэн мөрдөөгүй, нарийн магадлаагүй, үнэлгээний хорооны үйл ажиллагааны үр дүн хангалтгүй, шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, түүнд хяналт тавиагүй зэрэг зөрчлүүд давтагдан байгаа нь өмнө илэрсэн зөрчлийг арилгах талаар НИТХ, НЗД болон харьяа байгууллагын удирдлага, холбогдох ажилтнууд төрийн аудитын байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Иймд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлээ.

Дүгнэлт: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, зөрчлүүд дахин давтагдаж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн төсвөөр 2021 онд хэрэгжүүлэх ТАХ-г хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичигтэй уялдуулан, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, олон нийтийн саналд үндэслэсэн төлөвлөсөн байна.
2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангуулаагүй, хугацаандаа хэрэгжих боломжтой байдлыг тооцоогүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус бараа ажил үйлчилгээ төлөвлөсөн зэргээр төлөвлөлтийн хэрэгжилтийг дутуу хангасан байна.
3. ХАА зохион байгуулахдаа шаардлагад нийцээгүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан нь ХАА-ны өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж байна.
4. Захиалагчийн үйл ажиллагаанаас шалтгаалан 10,290.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 ТАХ дуусаагүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу зураг төсөвгүй, төсөвт өртгийг ерөнхий дүнгээр баталснаас ХАА хийгдэж, ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулагдсаны дараа төсөв нь магадлаар баталгаажсанаас шалтгаалж зарим ТАХ-ны нийт төсөвт өртөг нь 121,840.9 төгрөг хүртэл нэмэгдсэн байна. Мөн 1,996.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс хүлээн авсан ч ашиглагч байгууллага тодорхойгүйгээс ашиглалтгүй байна.
5. Гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотойгоор 16,234.7 сая төгрөгийн 16 ТАХ-ний гэрээний хэрэгжилт бүрэн хангагдаагүй байгаа нь захиалагчийн хяналт хангалтгүй байгааг харуулж байна.
6. Өмнөх онуудаас хэрэгжсэн 37,114.0 сая төгрөгийн дүнтэй 8 ТАХ газрын асуудал нь бүрэн шийдвэрлэгдээгүй, тухайн жилд санхүүжих дүнг бага хэмжээгээр тусгасан, түлхүүр гардуулах гэрээтэй ТАХ-ний зураг төсөл нь магадлалаар баталгаажихдаа төсөвт өртөг нь нэмэгдсэн зэргээр дуусаагүй байна.
7. ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслээгүй олгосон, ашиглагч байгууллага болон НӨАУГ нь төсөл арга хэмжээний 22.6%-г бүртгээгүй шалтгаан нь хөрөнгө оруулалтын шинж чанартай бус ТАХ байгаагаар холбоотой байна.
8. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, зөрчлүүд дахин давтагдаж байна.
9. Аудитаар нийт 137,802.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 6,931.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 85,429.9 сая төгрөг зөрчилд албан шаардлага, 45,441.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-д:

1. Нийслэлд шинээр хэрэгжих ТАХ-г ерөнхий нэрээр төлөвлөж байгаа зөрчлийг арилгуулж, санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран ТАХ нэг бүрийн төсөвлөлтийн шаардлагыг хангуулж хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээг төлөвлөж ажиллах;
2. ХАА зохион байгуулах тухай захирамжийг ХАА-ны мэргэжлийн байгууллагад хугацаа алдалгүй шилжүүлэх;
3. Цэцэрлэгт хүрээлэнгийн барилга байгууламжийн ашиглагч байгууллагыг тодорхой болгон эзэнжүүлэх;
4. Өмнөх онуудаас дуусаагүй 8 ТАХ-ний газрын болон төсөв хөрөнгийн асуудлыг шуурхай шийдвэрлэж, цаашид хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авах;
5. Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх явц, үр дүнд тавих хяналт, шат шатны хариуцлагыг сайжруулах;
6. Аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчил гаргасан холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хариуцлага тооцож, зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь эргэн мэдэгдэх.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт

1. Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль тогтоомжийн хүрээнд үнэлж, шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдлөгө болгох;
2. Аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар бодитой ажил хэрэгжүүлэн танилцуулах.

Нийслэлийн Замын хөгжлийн газар, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т

3. Гэрээний хэрэгжилтийн явцад тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, ажлыг дутуу болон чанаргүй гүйцэтгүүлсэн зөрчлүүдийг таслан зогсоож, стандартын шаардлагад нийцүүлэн засуулж, давтан гаргахгүй байх албан шаардлагыг биелүүлж, хугацаанд нь эргэн мэдэгдэх;
4. Захиалагчийн хяналт хэрэгжүүлдэг эрх бүхий нэгж, албан хаагчдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хяналтыг дутуу болон чанаргүй гүйцэтгүүлсэн албан хаагчдад хариуцлагыг тухай бүр хүлээлгэж хэвших.

/НАГ-2022/16-11-ШТА-ГА

Нийслэлийн Хэрэгнэ Оруулалтын Газар
Удирдлага
Газрын Дарга
БАЛЖИННЯМ МӨНХБАТ
2022.04.27 10:27

Саналд өгсөн тайлбар

НЗХГ, “НХОГ” ОНӨААТҮГ нь аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, санал нэг байгаагаа илэрхийлсэн. НЗД, НХААГ, НЭМГ -аас нэмэлт тайлбар ирүүлсэн ч хүлээн авах боломжгүй учир тайланд өөрчлөлт ороогүй болно.

Хавсралт

Хавсралт 1

Нийслэлд 2021 онд хэрэгжих ТАХ-г салбараар эрэмбэлсэн байдал

		сая.төг			
№	Хөрөнгө оруулалт /салбараар/	Шилжих болон Шинэ	Багц ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Эзлэх хувь
1	Хот байгуулалт, дэд бүтцийн салбар	Шилжих	33	183,137.90	39.8%
		Шинэ	13	24,355.9	5.3%
2	Авто замын салбар	Шилжих	22	72,326.7	15.7%
		Шинэ	23	34,775.6	7.6%
3	Хот нийтийн аж ахуйн салбар	Шилжих	19	45,445.4	9.9%
		Шинэ	2	267.7	0.1%
4	Нийгмийн салбар	Шилжих	2	6,263.5	1.4%
5	Төрийн үйлчилгээг сайжруулах	Шилжих	11	50,360.1	10.9%
		Шинэ	1	1,000.0	0.2%
6	Нийтийн тээврийн салбар	Шилжих	4	42,601.2	9.3%
		Шилжих	91	400,134.7	87%
	Нийт	Шинэ	39	60,399.2	13%
			130	460,533.9	100%

Хавсралт 2

Нийслэлд 2021 онд шинээр хэрэгжүүлэх 39 багц ТАХ-г захирамжаар задалсан байдал /хураангуй/

№	Тогтоолын дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Батлагдсан төсөл, арга хэмжээний				НЗД-ын захир амжаа р задар сан тоо	Захирам жилсан болон захирамж лаагүй дүн
			Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн		
1	58.1.1	“Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор” шинэ байранд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудыг шилжүүлэн байршуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын зардал	2021	2021	1,000.0	1,000.0	15	-
2	58.1.2	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн нийслэлийн хариуцах хөрөнгө	2021	2021	3,000.0	3,000.0	8	6.3
3	58.1.2	Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ	2021	2022	7,652.7	3,000.0	106	50.1
4	58.1.2	Газар чөлөөлөх нөхөх олговор	2021	2021	5,700.0	5,700.0	1	1.4
5	58.1.1	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зуслангийн 4 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол /СБД, ЧД/	2021	2021	200.0	200.0	1	-
6	58.1.1	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил /БГД, ХУД, ЧД/	2021	2022	1,932.6	1,000.0	6	-
7	58.1.3	Сургууль, цэцэрлэгийн барилгын засвар	2021	2021	500.0	500.0	7	-
8	58.1.3	Сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, засвар шинэчлэлт хийх төсөл /СХД, БЗД/	2021	2022	1,875.0	875.0	4	-
9	58.1.3	138 дугаар бага сургууль, 220 дугаар цэцэрлэгийн барилгын гадна түшиц хана, гадна	2021	2022	928.1	500.0	1	-

		талбайн засвар, үерийн хамгаалалтын шугам /ЧД, 12 дугаар хороо/						
10	58.1.3	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж	2021	2021	328.7	328.7	22	0.05
11	58.1.3	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын засвар	2021	2021	300.0	300.0	5	-
12	58.1.3	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж	2021	2021	500.0	500.0	16	-
13	58.1.3	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн хуучин барилгыг хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар засварлан тохижуулах ажил	2021	2022	638.8	300.0	1	-
14	58.1.3	Өвөлжилтийн бэлтгэл арга хэмжээ	2021	2021	800.0	800.0	13	-
15	58.1.9	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын цахилгаан шат	2021	2021	150.0	150.0	1	-
16	58.1.9	Дээвэр засварын ажил /Сүхбаатар дүүрэг 1, 5, 6, 7, 10 дугаар хороо/	2020	2021	117.7	112.7	1	0.019
17	A	Авто замын засвар, шинэчлэлтийн ажил	2021	2022	4,100.0	3,860.0	16	-
18	A	Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, судалгаа, зураг төсөл, зөвлөх үйлчилгээ	2021	2022	11,060.0	6,140.0	20	-
19	A	Онцгой байдлын давтан сургалт, сэргээн заслын төв-113 дугаар анги хүртэлх 1.8 км авто зам /ХУД, 8 дугаар хороо/	2021	2022	2,164.0	2,000.0	1	-
20	B	Хотын гол болон туслах гудамж замуудын засвар арчлалтын ажил	2021	2021	6,500.0	6,500.0	283	-
21	B	Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэг, хайс, тоноглолын засвар арчлалтын ажил	2021	2021	1,000.0	1,000.0	7	-
22	B	Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний ажил	2021	2021	2,000.0	2,000.0	64	-
23	B	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчиход ээлтэй орчин бүрдүүлэх	2021	2021	500.0	500.0	1	-
24	B	Гүүр, хоолой, туннеллын засварын ажил	2021	2021	500.0	500.0	13	-
25	B	Авто замын хөдөлгөөн зохицуулах гэрэл дохионы засвар арчлалт хийх, шилэн кабель татах ажил	2021	2021	1,000.0	1,000.0	24	-
26	B	Сургууль, цэцэрлэг орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах ажил	2021	2021	500.0	500.0	12	-
27	B	Замын ус зайлуулах шугам, худгийн засвар, өргөтгөл	2021	2021	1,000.0	1,000.0	13	-
28	B	Уулзвар, замын нэвтрүүлэх чадварыг сайжруулах зам барилгын ажил	2021	2021	650.0	650.0	1	-
29	B	Багануур дүүргийн авто замын засвар	2021	2021	472.7	472.7	1	-
30	B	Багахангай дүүргийн авто замын засвар	2021	2021	59.6	59.6	1	-
31	B	Налайх дүүргийн авто замын засвар	2021	2021	550.4	550.4	1	-
32	B	Нийтийн тээврийн хэрэгслийн зориулалтын зогсоол	2021	2021	300.0	300.0	9	1.0
33	B	"Нийслэлийн авто замын сүлжээний арчлалт, урсгал засварын ажлын төлөвлөлт, санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх" зөвлөх үйлчилгээ	2021	2021	350.0	350.0	1	-
34	B	Нийтийн өмчийн авто замын нэгдсэн кадастрын зураглал бий болгож, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, хөдөлгөөний эрчмийн ээлжит тооллого судалгааны ажил	2021	2021	400.0	400.0	1	-
35	B	Инженер, техникийн ажилчдыг салбарын чиглэлээр мэргэшүүлэх, бэлтгэх	2021	2021	100.0	100.0	1	-
36	B	Нийслэлийн авто замын хөгжлийн газрын Материал шинжилгээний лабораторт шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	2021	2021	200.0	200.0	1	-
37	G	"Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц барих төсөл"-ийн зөвлөх үйлчилгээ	2021	2021	417.5	417.5	1	0.02
38	G	Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн зөвлөх үйлчилгээ, зохиогчийн хяналтын зардал	2021	2021	267.6	267.6	2	-
39	D	Магадлашгүй ажил	2021	2021	683.8	683.8	3	16.2
		НИЙТ			60,399,2	47,718,0	685	75,01

Хавсралт 3

ТАХ-ний төрөл

№	Төрөл	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	сая.төг
				ТАХ-ний эзлэх хувь
1	Авто замын барилга байгууламж, өргөтгөл, шинэчлэлт, засвар, гүүр хоолой, тэмдэг тэмдэглэгээ	26,579.40	130	42.2%
2	Барилга, барилгын засвар, орчны тохижилт	11,340.10	43	13.9%
3	Зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ	17,593.90	111	36.0%
4	Машин, техник, тавилга тоног төхөөрөмж	6,398.90	24	7.7%
	Нийт	61,912.30	308	100%

Хавсралт 4

Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой зөрчлийн жагсаалт

№	ХАА зохион байгуулсан байгууллага	ТАХ нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэгчийн нэр	сая.төг
					Зөрчлийн утга
1	НХААГ	Дүнжингаравын уулзвараас Амгалан чиглэлд төмөр замын хойд талд хийгдэх туслах гудамж зам (Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо)	82,5	Эс Ар Пи Инженеринг Консалтинг Монголиа ХХК	Техникийн саналын нээлтийн тэмдэглэлд үнэлгээний хорооны дарга Г.Анар, гишүүд Н.Дарьцогзол, Г.Дөлгөөн, Б.Ертис нарын гарын үсэг зурагдаагүй.
2	НХААГ	Дүнжингаравын уулзвараас Амгалан чиглэлд төмөр замын урд талд хийгдэх туслах гудамж, зам (Баянзүрх дүүрэг, 13, 14 дүгээр хороо)	136,3	Эс Ар Пи Инженеринг Консалтинг Монголиа ХХК	Техникийн саналын нээлтийн тэмдэглэлд үнэлгээний хорооны дарга Г.Анар, гишүүд Н.Дарьцогзол, Г.Дөлгөөн, Б.Ертис нарын гарын үсэг зурагдаагүй.
3	НХААГ	Жалханз хутагт Дамдинбазарын гудамжнаас Тээврийн дээд сургууль хүртэлх авто зам (Баянгол дүүрэг, 18 дугаар хороо)	64,2	Засмал зам ХХК	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.6-д үнэлгээний хорооны гишүүд ХАА-ны чиглэлээр мэргэшсэн байна гэж заасан байхад үнэлгээний хорооны дарга Г.Анар, гишүүд Г.Дөлгөөн, Б.Ертис, Ц.Болормаа, нарын АЗ сертификатын хуулбар байхгүй.
4	НХААГ	Дарь-Эхийн уулзвар орчим Шинэ айл худалдааны төвийн баруун талаар Сэлбэ гол дагасан авто зам	87,9		Үнэлгээний хорооны гишүүдийн АЗ сертификат байхгүй Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлаагүй
5	НХААГ	Нарны гүүрний баруун тал ДЭМА эмнэлгийн хойд талд хийгдэх авто зам	39,7	Классик роуд ХХК	Техникийн саналын нээлтийн тэмдэглэлд НБДарга гарын үсэг зураагүй Маягт 3.3, 3.4, 3.5-г баталгаажуулаагүй
6	НХААГ	69Б байрны урдуурх авто зам	18,3	Эс Ар Пи инженеринг консалтинг монголиа ХХК	Тендерийн нээлтийн тэмдэглэлд Д.Батсүх, Б.Ертис нар гарын үсэг зураагүй
7	НХААГ	Б.Амарсанаагийн гудамжны зүүн талын туслах гудамж зам	36,7	Эс Ар Пи инженеринг консалтинг монголиа ХХК	Тендерийн нээлтийн тэмдэглэлд Д.Батсүх, Г.Дөлгөөн нар гарын үсэг зураагүй Үнэлгээний хорооны 5, 6 дугаар хурлын тэмдэглэлд Д.Батсүх, Г.Дөлгөөн гарын үсэг зураагүй.
8	НХААГ	Дарь-Эхийн авто замаас баруун тийш гэр хороолол дундуур шинээр баригдах авто зам	9,9	Геоураглал	Г.Анар, Б.Ертис, Ц.Болормаа нарын Үнэлгээний хорооны гишүүдийн АЗ сертификат байхгүй. Тендерт шалгарсан Гео зураглал ХХК-ийн архивын баримт байхгүй.

Хавсралт 5

ТББ-т тусгасан зарим шаардлага хангаагүй гүйцэтгэгчдийн жагсаалт

сая.төг

№	ХАА зохион байгуулсан байгууллага	ТАХ нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэгчийн нэр	Зөрчлийн утга
1	НХААГ	138 дугаар бага сургууль, 220 дугаар цэцэрлэгийн барилгын гадна түшиц хана, гадна талбайн засвар, үерийн хамгаалалтын шугам /ЧД, 12 дугаар хороо/	928.1	Модернхас ХХК	ТББ-ийн ТӨӨЗ-ны 5.2в-д Усны барилга байгууламжийн инженерийн мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага нь 3 болон түүнээс дээш байх гэж заасан байхад тендерт оролцогчийн санал болгосон усны барилга байгууламжийн инженер С.Бямбаагийн ажлын туршлагыг нотлох баримт ирүүлээгүй, баримтаар нотлогдоогүй.

2	НХААГ	Барс хоёр захын баруун талаар шинээр баригдах авто зам (Баянгол дүүрэг, 20 дугаар хороо)	17.6	Геоураглал ХХК	ТББ-ийн ТӨЗ 4.4.4-т заасан зургийн техникч нь энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 1 жилд зураг төслийн ажилд ажилласан байх гэж заасан байхад тендерт оролцогчийн санал болгосон зургийн техникч тухайн чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 1 жилд зураг төслийн ажилд ажилласан нотлох баримт ирүүлээгүй, баримтаар нотлогдоогүй.
